# ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

№ 20 (545)

**МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ**

- *Татварын ерөнхий хууль үзүүлэх тухай хуульд өөрчлөлт оруулах тухай*
- *Монгол Улсын баатар, хөдөлмөрийн баатар, ардын болон гавьяат цолтон ахмад настанд төрөөс олгох нэмэгдлийн тухай*
- *Цацрагийн хамгаалалт, аюулгүй байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай*

**Улсын Их Хурлын Тамгын газар**
**Улаанбаатар хот**
**2008 он**

# ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН АЛБАН МЭДЭЭЛЭЛ

Долоо хоног тутмын

Улаанбаатар хот | 2008 оны тавдугаар сарын 29 | №20 (545)


## Гарчиг

### Нэг. МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ


| | | | |
|---|---|---|---|
| 297. | Татварын ершөөл үзүүлэх тухай хуульд өөрчлөлт оруулах тухай | | 470 |
| 298. | Монгол Улсын баатар, хөдөлмөрийн баатар, ардын болон гавъяат цолтон ахмад настанд төрөөс олгох нэмэгдлийн тухай | | 470 |
| 299. | Ахмад настны нийгмийн хамгааллын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай | | 472 |
| 300. | Ажиллах хүч харилцан солилцох тухай Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Ардчилсан Солонгос Ард Улсын Засгийн газар хоорондын хэлэлцээрийг соёрхон батлах тухай | | 472 |
| 301. | Үндэстэн дамнасан зохион байгуулалттай гэмт хэргийн эсрэг конвенц, түүний нэмэлт болох хүн ялангуяа эмэгтэйчүүд, хүүхэд худалдаалахаас урьдчилан сэргийлэх, таслан зогсоох, шийтгэх тухай протокол, шилжин суурьшигчдыг газраар, далайгаар болон агаараар хууль бусаар оруулахын эсрэг протокол, галт зэвсэг, бүрдэл хэсэг, зэд анги, галт хэрэгслийг хууль бусаар тээвэрлэх, үйлдвэрлэхийн эсрэг протоколд нэгдэн орсныг соёрхон батлах тухай | | 472 |
| 302. | Цацрагийн хамгаалалт, аюулгүй байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай | | 473 |
| 303. | Монгол Улсын Засгийн газрын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай | | 473 |


### Хоёр. МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ


| | | | |
|---|---|---|---|
| 304. | Улсын Их Хурлын гишүүний төсөвт зардлыг төлөвлөх, тооцох, зарцуулах, тайлагнах журам батлах, зарим зардлын хэмжээг шинэчлэн тогтоох тухай | Дугаар 28 | 473 |
| 305. | Төрөөс олгох нэмэгдлийн хэмжээ тогтоох тухай | Дугаар 33 | 477 |
| 306. | Тогтоолын хавсралтад өөрчлөлт оруулах тухай | Дугаар 34 | 477 |
| 307. | Тогтоолын хавсралтад нэмэлт оруулах тухай | Дугаар 35 | 477 |
| 308. | Үндсэн хуулийн цэцийн 2008 оны 06 дугаар дүгнэлтийн тухай | Дугаар 38 | 478 |
| 309. | Монакогийн Хант Улстай дипломат харилцаа тогтоох тухай | Дугаар 44 | 478 |
| 310. | Тогтоолын хавсралтад нэмэлт оруулах тухай | Дугаар 45 | 478 |
| 311. | Үндсэн хуулийн цэцийн гишүүний албан ажлын онцгой нөхцөлийн нэмэгдлийн хэмжээг шинэчлэн тогтоох тухай | Дугаар 46 | 479 |


### Гурав. МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ


| | | | |
|---|---|---|---|
| 312. | Хаягжилтын нэгдсэн систем бий болгох тухай | Дугаар 77 | 479 |
| 313. | Монгол Улсад бүртгэл, мэдээллийн нэгдсэн тогтолцоог бий болгох үндэсний хөтөлбөр батлах тухай | Дугаар 78 | 479 |

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2008 оны 05 дугаар сарын 09-ний өдөр

Улаанбаатар хот

### ТАТВАРЫН ӨРШӨӨЛ ҮЗҮҮЛЭХ ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.** Татварын өршөөл үзүүлэх тухай хуулийн 6 дугаар зүйлийг дараах байдлаар өөрчлөн найруулсугай:

**"6 дугаар зүйл. Өршөөлд хамааруулах албан татвар, нийгмийн даатгалын өр, төлбөр**

6.1. 2007 оны 12 дугаар сарын 28-ны өдөр батлагдсан Татварын зарим хууль болон Нийгмийн даатгалын тухай хуулийг хэрэгжүүлэх тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.3-т заасан албан татвар, нийгмийн даатгалын шимтгэлийн дараах өр, хүү, торгууль, алдангийг дор дурдсан хувиар тооцож чөлөөлнө:

6.1.1. 2006 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар тасалбар болгон гаргаж татварын албаны баталгаажуулсан албан татварын өрөөс 2008 оны 1 дүгээр сарын 1-ний өдрийн байдлаар барагдаагүй үлдсэн албан татварын хүү, торгуулийг 100 хувь, 2007 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар хуулийн этгээдийн төлбөл зохих нийгмийн даатгалын шимтгэлийн өрөөс барагдаагүй үлдсэн алдангийг 100 хувь;

6.1.2. Татварын ерөнхий хуулийн 13.2-т заасан хөөн хэлэлцэх хугацаа дууссан албан татварын үндсэн өрийг 100 хувь;

6.1.3. 2006 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар тасалбар болгон гаргаж татварын албаны баталгаажуулсан албан татварын үндсэн өрөөс 2008 оны 1 дүгээр сарын 1-ний байдлаар төлөгдөөгүй байгаа өрийн 10 хувийг 2009 оны 1 дүгээр сарын 1-ний дотор төлсөн тохиолдолд үлдэх 90 хувийг;

6.1.4. 2007 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар хуулийн этгээдийн төлбөл зохих нийгмийн даатгалын шимтгэлийн эргэж төлөгдөх найдваргүй өрийг 100 хувь;

6.1.5. Эрүүгийн хуулийн 166, 167 дугаар зүйлийг үндэслэн, түүнчлэн Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд заасныг баримтлан гаргасан шүүхийн шийтгэх тогтоол, шийдвэрээр оногдуулсан албан татварын үндсэн өрийн 50 хувийг төлсөн тохиолдолд үлдэх 50 хувийг;

6.1.6. эрх бүхий байгууллагын шийдвэр гарч банкны өр барагдуулах алба, шүүхийн шийдвэр гүйцэтгэх газарт гүйцэтгэгдэж байгаа албан татварын өрийг 100 хувь."

**2 дугаар зүйл.** Татварын өршөөл үзүүлэх тухай хуулийн 1 дүгээр зүйлийн 1.1-ийн "өр, төлбөр" гэснийг "өр, төлбөрийн тодорхой хувиас" гэж өөрчилсүгэй.

**3 дугаар зүйл.** Энэ хуулийг батлагдсан өдрөөс нь эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА Д.ЛҮНДЭЭЖАНЦАН**

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2008 оны 05 дугаар сарын 16-ны өдөр

Улаанбаатар хот

### МОНГОЛ УЛСЫН БААТАР, ХӨДӨЛМӨРИЙН БААТАР, АРДЫН БОЛОН ГАВЬЯАТ ЦОЛТОН АХМАД НАСТАНД ТӨРӨӨС ОЛГОХ НЭМЭГДЛИЙН ТУХАЙ

**1 дүгээр зүйл. Хуулийн зорилт**

1.1.Энэ хуулийн зорилт нь Монгол Улсын баатар, хөдөлмөрийн баатар, ардын болон гавьяат цолтон ахмад настанд төрөөс нэмэгдэл олгохтой холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

**2 дугаар зүйл. Хууль тогтоомж**

2.1.Энэ хуулиар тогтоосон нэмэгдэл олгох тухай хууль тогтоомж нь Үндсэн хууль, Нийгмийн халамжийн тухай, Ахмад настны нийгмийн хамгааллын тухай хууль, энэ хууль болон тэдгээртэй нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад актаас бүрдэнэ.

**3 дугаар зүйл. Хуулийн нэр томъёоны тодорхойлолт**

3.1."Төрөөс олгох нэмэгдэл" /цаашид "нэмэгдэл" гэх/ гэж энэ хуульд заасан болзлыг

хангасан Монгол Улсын иргэнд нийгмийн даатгал, нийгмийн халамжийн сангаас олгож байгаа тэтгэвэр, тэтгэмжээс гадна төрөөс сар бүр олгох мөнгөн хэрэнгийг олгоно.

**4 дүгээр зүйл. Хуулийн үйлчлэх хүрээ**

4.1.Ахмад настны нийгмийн хамгааллын тухай хуулийн 3.1-д заасан насанд хүрсэн Монгол Улсын баатар, хөдөлмөрийн баатар, ардын болон гавьяат цол хүртсэн Монгол Улсын иргэнд энэ хууль үйлчилнэ.

**5 дугаар зүйл. Нэмэгдэл авах эрх**

5.1.Энэ хуулийн 4 дүгээр зүйлд заасан болзлыг хангасан ахмад настан мөн хуулийн 3 дугаар зүйлд заасан нэмэгдэл авах эрхтэй.

5.2.Ахмад настан нь энэ хуулийн 4.1-д заасан цолыг давхардуулан хүртсэн бол түүнд аль өндөр хэмжээтэй нэмэгдэл олгоно.

**6 дугаар зүйл. Нэмэгдлийн хэмжээ**

6.1.Нэмэгдлийн хэмжээг Засгийн газрын өргөн мэдүүлснээр Улсын Их Хурал тогтооно.

6.2.Хөдөлмөрийн хөлсний доод хэмжээний өсөлттэй уялдуулан Улсын Их Хурал нэмэгдлийн хэмжээг шинэчлэн тогтоож болно.

**7 дугаар зүйл. Бүрдүүлэх баримт бичиг**

7.1.Нэмэгдэл авахыг хүсэгч дараахь баримт бичиг бүрдүүлнэ:

7.1.1.нэмэгдэл авахыг хүссэн өргөдөл;

7.1.2.иргэний үнэмлэх;

7.1.3.Улсын баатар, хөдөлмөрийн баатар, ардын болон гавьяатын цолны үнэмлэх.

**8 дугаар зүйл. Нэмэгдэл олгох**

8.1.Нэмэгдлийг улсын төсвөөс олгоно.

8.2.Нэмэгдлийг дүүргийн нийгмийн халамж, үйлчилгээний байгууллага, сумын нийгмийн ажилтан энэ хуулийн 7.1-д заасан баримт бичгийг үндэслэн арилжааны банкаар дамжуулан сар бүр олгоно.

8.3.Нэмэгдлийг ахмад настанд энэ хуулийн 7.1-д заасан өргөдөл гаргасан өдрөөс эхлэн олгоно.

8.4.Нэмэгдлийг тухайн ахмад настны хүсэлтээр улирлын болон жилийн эцэст олгож болно.

8.5.Нийгмийн халамж, үйлчилгээний байгууллага ахмад настны хүсэлтээр нэмэгдлийг өөрийнх нь хадгаламжийн дансанд шилжүүлж болно.

**9 дүгээр зүйл. Нэмэгдлийг зогсоох, нөхөн төлүүлэх**

9.1.Нэмэгдэл авдаг ахмад настан нас барвал нэмэгдлийг нас барсны дараагийн сар дуустал олгоно.

9.2.Хуурамч бичиг баримт бүрдүүлж нэмэгдэл авсан нь тогтоогдвол түүний олголтыг зогсоож, олгогдсон нэмэгдлийг нөхөн төлүүлнэ.

9.3.Дүүргийн нийгмийн халамж, үйлчилгээний байгууллага, сумын нийгмийн ажилтны буруугаас илүү олгогдсон нэмэгдлийг буцаан суутгахгүй бөгөөд хохирлыг шүүхийн журмаар буруутай албан тушаалтнаар нөхөн төлүүлнэ.

9.4.Энэ хуулийн 9.3-т заасан байгууллага, албан тушаалтны буруугаас дутуу олгогдсон нэмэгдлийг ахмад настанд нөхөн олгоно.

**10 дугаар зүйл. Хууль тогтоомж зөрчигчид хүлээлгэх хариуцлага**

10.1.Монгол Улсын баатар, хөдөлмөрийн баатар, ардын болон гавьяат цолтон ахмад настанд төрөөс олгох нэмэгдлийн тухай хууль тогтоомжийг зөрчсөн гэм буруутай этгээдэд хууль тогтоомжид заасны дагуу хариуцлага хүлээлгэнэ.

**11 дүгээр зүйл. Хууль хүчин төгөлдөр болох**

11.1.Энэ хуулийг 2008 оны 7 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА Д.ЛҮНДЭЭЖАНЦАН

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2008 оны 05 дугаар сарын 16-ны өдөр

Улаанбаатар хот

### АХМАД НАСТНЫ НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.** Ахмад настны нийгмийн хамгааллын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 2 дахь хэсгийн "улсын тусгай тэтгэвэр" гэснийг "төрөөс олгох нэмэгдэл" гэж өөрчилсүгэй.

**2 дугаар зүйл.** Энэ хуулийг Монгол Улсын баатар, хөдөлмөрийн баатар, ардын болон гавьяат цолтон ахмад настанд төрөөс олгох нэмэгдлийн тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА Д.ЛҮНДЭЭЖАНЦАН**

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2008 оны 05 дугаар сарын 16-ны өдөр

Улаанбаатар хот

### АЖИЛЛАХ ХҮЧ ХАРИЛЦАН СОЛИЛЦОХ ТУХАЙ МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР, БҮГД НАЙРАМДАХ АРДЧИЛСАН СОЛОНГОС АРД УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР ХООРОНДЫН ХЭЛЭЛЦЭЭРИЙГ СОЁРХОН БАТЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.** 2007 оны 7 дугаар сарын 20-ны өдөр Улаанбаатар хотноо гарын үсэг зурсан Ажиллах хүч харилцан солилцох тухай Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Ардчилсан Солонгос Ард Улсын Засгийн газар хоорондын хэлэлцээрийг Монгол Улсын Засгийн газрын өргөн мэдүүлснээр соёрхон батлагсугай.

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА Д.ЛҮНДЭЭЖАНЦАН**

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2008 оны 05 дугаар сарын 16-ны өдөр

Улаанбаатар хот

### ҮНДЭСТЭН ДАМНАСАН ЗОХИОН БАЙГУУЛАЛТТАЙ ГЭМТ ХЭРГИЙН ЭСРЭГ КОНВЕНЦ, ТҮҮНИЙ НЭМЭЛТ БОЛОХ ХҮН, ЯЛАНГУЯА ЭМЭГТЭЙЧҮҮД, ХҮҮХЭД ХУДАЛДААЛАХААС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ, ТАСЛАН ЗОГСООХ, ШИЙТГЭХ ТУХАЙ ПРОТОКОЛ, ШИЛЖИН СУУРЬШИГЧДЫГ ГАЗРААР, ДАЛАЙГААР БОЛОН АГААРААР ХУУЛЬ БУСААР ОРУУЛАХЫН ЭСРЭГ ПРОТОКОЛ, ГАЛТ ЗЭВСЭГ, БҮРДЭЛ ХЭСЭГ, ЭД АНГИ, ГАЛТ ХЭРЭГСЛИЙГ ХУУЛЬ БУСААР ТЭЭВЭРЛЭХ, ҮЙЛДВЭРЛЭХИЙН ЭСРЭГ ПРОТОКОЛД НЭГДЭН ОРСНЫГ СОЁРХОН БАТЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.** НҮБ-ын Ерөнхий Ассамблейгаас 2000 оны 11 дүгээр сарын 15-ны өдөр батлсан Үндэстэн дамнасан зохион байгуулалттай гэмт хэргийн эсрэг конвенц, түүний нэмэлт болох Хүн, ялангуяа эмэгтэйчүүд, хүүхэд худалдаалахаас урьдчилан сэргийлэх, таслан зогсоох, шийтгэх тухай 2000 оны 11 дүгээр сарын 15-ны өдрийн протокол, Шилжин суурьшигчдыг газраар, далайгаар болон агаараар хууль бусаар оруулахын эсрэг 2000 оны 11 дүгээр сарын 15-ны өдрийн протокол, Галт зэвсэг, бүрдэл хэсэг, эд анги, галт хэрэгслийг хууль бусаар тээвэрлэх, үйлдвэрлэхийн эсрэг 2001 оны 5 дугаар сарын 31-ний өдрийн протоколд Монгол Улс тус тус нэгдэн орсныг Засгийн газрын өргөн мэдүүлснээр соёрхон баталсугай.

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА Д.ЛҮНДЭЭЖАНЦАН**

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2008 оны 05 дугаар сарын 22-ны өдөр | Улаанбаатар хот

### ЦАЦРАГИЙН ХАМГААЛАЛТ, АЮУЛГҮЙ БАЙДЛЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.** Цацрагийн хамгаалалт, аюулгүй байдлын тухай хуулийн 5.1 дэх хэсгийн "аюулгүй байдлыг хангах бодлого боловсруулах" гэсний дараа ",мэргэжлийн хяналт тавих" гэж нэмсүгэй.

**2 дугаар зүйл.** Цацрагийн хамгаалалт, аюулгүй байдлын тухай хуулийн 5.1-ийн "Шинжлэх ухааны асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний эрхлэх асуудлын" гэснийг "Монгол Улсын Ерөнхий сайдын эрхлэх ажлын" гэж, 5.2-ын "Шинжлэх ухааны асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн" гэснийг "Монгол Улсын Ерөнхий сайд" гэж тус тус өөрчилсүгэй.

**3 дугаар зүйл.** Энэ хуулийг 2008 оны 6 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА Д.ЛҮНДЭЭЖАНЦАН**

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2008 оны 05 дугаар сарын 22-ны өдөр | Улаанбаатар хот

### МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.** Засгийн газрын тухай хуулийн 20.4 дэх хэсэгт "цацраг идэвхт ашигт малтмал болон цөмийн энерги ашиглах асуудал" гэж нэмсүгэй.

**2 дугаар зүйл.** Энэ хуулийг Цацрагийн хамгаалалт, аюулгүй байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА Д.ЛҮНДЭЭЖАНЦАН**

## МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2008 оны 05 дугаар сарын 06-ны өдөр | Дугаар 28 | Улаанбаатар хот

### Улсын Их Хурлын гишүүний төсөвт зардлыг төлөвлөх, тооцох, зарцуулах, тайлагнах журам батлах, зарим зардлын хэмжээг шинэчлэн тогтоох тухай

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 34.13, 35.1-35.9 дэх хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1.Улсын Их Хурлын гишүүнд бүрэн эрхээ хэрэгжүүлэхэд нь зайлшгүй шаардлагатай зарим төсөвт зардлын хэмжээг дор дурдсанаар тогтоосугай:

1/Улсын Их Хурал, Монголын Парламентын Бүлгэмийн албан ёсны айлчлал болон танилцах аялалаар гадаад арга хэмжээнд оролцоход нь бэлэг дурсгалын зардлын хэмжээг орон тус бүрт 50,0 мянга хүртэл төгрөгөөр;

2/албан ажлын шугамаар гадаад, дотоодын зочин, төлөөлөгч хүлээн авах, бэлэг дурсгалын зүйл өгөх зардлын хэмжээг улирвалд 180.0 мянга хүртэл төгрөгөөр;

3/үйл ажиллагааныхаа талаар тойргийн сонгогчид, олон нийтэд мэдээлэх, сурталчлах, зайлшгүй шаардлагатай бусад мэдээлэл цуглуулах, зарим ном, хэвлэлийг захиалан хэрэглэхэд нь дэмжлэг үзүүлэх зорилгоор олгох зардлын хэмжээг улиралд 120.0 мянган төгрөгөөр;

4/ажлын зайлшгүй шаардлага, нийтлэг жишгийг харгалзан үүрэн телефон утасны төлбөрийн зарим хэсэгт зориулан улсын төсвөөс төлөх зардлын хэмжээг сар тутам Улсын Их Хурлын дэд даргад 200.0 мянган төгрөг, Байнгын хорооны даргад 140.0 мянган төгрөг,

Улсын Их Хурлын бусад гишүүдэд 120.0 мянган төгрөгөөр.

2.Хотын дотор хэрэглэх унааны лимитийг албан тушаалын суудлын автомашин хэрэглэх Улсын Их Хурлын дэд даргад хуанлийн хоногт 70 км, албан ажлын суудлын автомашин хэрэглэх Байнгын хорооны даргад ажлын хоногт 70 км, Улсын Их Хурлын бусад гишүүнд ажлын хоногт 50 км байхаар тус тус тогтоосугай.

3.Улсын Их Хурлын гишүүний төсөвт зардлыг төлөвлөх, тооцох, зарцуулах, тайлагнах журмыг 1 дүгээр хавсралтаар, сонгогдсон тойрогтоо жилд ажиллах унааны лимитийг 2 дугаар хавсралтаар тус тус батлсугай.

4.Улсын Их Хурлын гишүүний хангамж, үйлчилгээ, нийгмийн асуудлыг шийдвэрлэхтэй холбогдсон энэ тогтоолд тусгагдаагүй зарим зардлын хэмжээг Улсын Их Хурлын дарга захирамжаараа тогтоож байсугай.

5.Энэ тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн байгуулалтын байнгын хороонд үүрэг болгосугай.

6.Энэ тогтоол гарсантай холбогдуулан "Улсын Их Хурлын гишүүний төсөвт зардлыг төлөвлөх, тооцох, зарцуулах, тайлагнах тухай журмыг батлах, зарим зардлын хэмжээг шинэчлэн тогтоох тухай" Улсын Их Хурлын 1999 оны 10 дугаар сарын 14-ний өдрийн 70 дугаар тогтоол, "Журам батлах, зарим зардлын хэмжээ тогтоох тухай" Улсын Их Хурлын 1997 оны 2 дугаар сарын 6-ны өдрийн 15 дугаар тогтоолыг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

7.Энэ тогтоолыг Улсын Их Хурлын 2008 оны ээлжит сонгуулиар шинээр сонгогдсон Улсын Их Хурлын гишүүдийн бүрэн эрх эхэлсэн өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН**
**ИХ ХУРЛЫН ДАРГА Д.ЛҮНДЭЭЖАНЦАН**

**Улсын Их Хурлын 2008 оны**
**28 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралт**

## УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮНИЙ ТӨСӨВТ ЗАРДЛЫГ ТӨЛӨВЛӨХ, ТООЦОХ, ЗАРЦУУЛАХ, ТАЙЛАГНАХ ЖУРАМ

### Нэг. Нийтлэг үндэслэл

1.1.Улсын Их Хурлын гишүүн /цаашид "гишүүн" гэх/ нь бүрэн эрхээ хэрэгжүүлэхэд шаардагдах зардлын тодорхой төсөвтэй байна.

1.2.Гишүүний өөрийн төсөвт зардал нь дор дурдсан бүрэлдэхүүнтэй байна:

1.2.1.үндсэн цалин;

1.2.2.албан ажлын онцгой нөхцөлийн болон бусад нэмэгдэл;

1.2.3.үүрэн телефон утасны зардлын зарим хэсэг;

1.2.4.хэвлэл, мэдээлэл, сурталчилгааны холбогдолтой зардлын хөнгөлөлт;

1.2.5.гишүүний хувьд оролцох гадаад арга хэмжээний болон дотооддоо зохион байгуулах ёслол, хүндэтгэлийн арга хэмжээ /бэлэг дурсгалын, хүлээн авалтын гэх мэт/-ний зардал;

1.2.6.сонгогдсон тойрогтоо ажиллах томилолтын зардал;

1.2.7.гэрээний үндсэн дээр ажиллуулах орон тооны туслахын зардал;

1.2.8.хотын дотор хэрэглэх унаа /суудлын автомашин/-ны зардал;

1.2.9.холбогдох шийдвэрийн дагуу олгох бусад зардал.

1.3.Засгийн газрын гишүүнээр томилогдсон гишүүнд энэ журмын 1.2.4-1.2.7-д заасан зардлын төсөв хамаарна.

1.4.Гишүүний бүрэн эрхээ хэрэгжүүлэхтэй холбогдсон нийтлэг арга хэмжээний дараахь зардлыг Улсын Их Хурлын жил бүрийн төсөвт тусгана:

1.4.1.нийгмийн даатгалын шимтгэл;

1.4.2.Улсын Их Хурал, Байнгын хорооны шугамаар орон нутагт ажиллах томилолтын зардал;

1.4.3.холбооны зардал /албан өрөөний утасны зардал, зөвшөөрөгдсөн пароль буюу кодоор хот хоорондын яриа, факсын зардал/;

1.4.4.Улсын Их Хурлын шугамаар зохиогдох ёслол, хүндэтгэлийн зэрэг нийтлэг арга хэмжээний унааны зардал;

1.4.5.бичиг хэрэг, шуудангийн зардал;

1.4.6.эд хогшил, тоног төхөөрөмж, сэлбэг, материал худалдан авах зардал; *

1.4.7.тэтгэвэр, тусламж, шагнал, урамшууллын зориулалттай зарим зардал;

1.4.8.сонгогдсон тойрогт нь ажиллах бие төлөөлөгч-туслахын зардал;

1.4.9.Улсын Их Хурлын үйл ажиллагаатай холбогдсон судалгаа, мэдээлэл, сурталчилгааны зардал;

1.4.10.гишүүний бүрэн эрхийн хугацаанд түүний амь нас, эрүүл мэнд, гэнэтийн ослын даатгалын хураамжийн зардал;

1.4.11.холбогдох шийдвэрийн дагуу төсөвлөгдсөн бусад зардал.

**Хоёр. Гишүүний төсөвт зардлыг төлөвлөх, тооцох журам**

2.1.Энэ журмын 1.2.1-1.2.5-д заасан гишүүний өөрийн төсөвт зардал тус бүрийг Улсын Их Хурлаас тогтоосон зардлын хэмжээгээр тооцон төлөвлөнө.

2.2..Энэ журмын 1.2.6-д заасан гишүүний сонгогдсон тойрогтоо ажиллах томилолтын зардалд дараахь зардлыг тооцон төлөвлөнө:

2.2.1.тогтоосон лимитийн дагуу олгох унааны зардал;

2.2.2.орон нутгаас сонгогдсон гишүүнд тухайн аймаг, орон нутагт очих, ирэх замын болон ор хоногийн зардал;

2.2.3.амь насны даатгалын зардал.

2.3.Энэ журмын 1.2.8-д заасан хотын дотор хэрэглэх унааны зардлыг Улсын Их Хурлаас тогтоосон лимит, автобаазтай байгуулсан гэрээнд заасан тарифыг үндэслэн төлөвлөнө.

2.4.Унаа, ор хоногийн зардал, тухайн аймаг, орон нутагт очих, ирэх замын зардал болон амь насны даатгалын зардлын хэмжээг төлөвлөхдөө тухайн үеийн үнэ тарифыг үндэслэнэ.

2.5.Гишүүний бие төлөөлөгч-туслахын цалин, шаардлагатай бусад зардлыг хууль тогтоомжид заасныг үндэслэх бөгөөд бичиг хэрэг, шуудан холбоо, тойрогт ажиллах томилолтын зардал зэргийг өмнөх жилийн төсвийн гүйцэтгэл болон дундаж нормыг баримтлан төлөвлөнө.

2.6.Улсын Их Хурлын Тамгын газар /цаашид "Тамгын газар" гэх/ нь энэ журмын 1.4-т заасан гишүүний нийтлэг арга хэмжээний зардал тус бүрийг холбогдох хууль тогтоомж, мөрдөж буй жишиг, урьд жилүүдийн дундаж гүйцэтгэл, инфляц, үнэ тарифын өөрчлөлт зэргийг харгалзан төлөвлөж, хэрэгжилтийг зохион байгуулна.

**Гурав. Гишүүний төсвийг зарцуулах, тайлагнах журам**

3.1.Тамгын газрын Санхүү, үйлчилгээний хэлтэс /цаашид "Санхүү, үйлчилгээний хэлтэс" гэх/ нь гишүүний өөрийн төсөвт зардлыг гишүүн бүрийн нэрээр төсөвлөн, тэдний зөвшөөрөлтэйгээр зориулалтынх нь дагуу зарцуулна.

3.2.Гишүүний төсвийн гүйцэтгэлийг тэдний бүрдүүлж, гарын үсэг зурж баталгаажуулсан зарцуулалтын тайлан, холбогдох санхүүгийн баримтыг үндэслэн Санхүү, үйлчилгээний хэлтэс улирал бүр гаргаж, гишүүн тус бүрт танилцуулна.

3.3.Гишүүн болон бие төлөөлөгч-туслах нь өөрийн үйл ажиллагаандаа зориулагдсан төсвийн зарцуулалтын тайлан, холбогдох санхүүгийн баримтыг зохих хууль тогтоомжийн дагуу үнэн зөв бүрдүүлж, тогтоосон журмын дагуу Санхүү, үйлчилгээний хэлтэст тухай бүр гаргаж өгөх үүрэгтэй.

3.4.Санхүү, үйлчилгээний хэлтэс нь гишүүн болон бие төлөөлөгч- туслахын төсвийн гүйцэтгэлийг гаргахдаа хэтрэлт, хэмнэлтийг зардлын зүйл, анги тус бүрээр тооцон мэдээлж, холбогдох арга хэмжээг авч хэрэгжүүлнэ.

3.5.Гишүүн өөрөө хүсвэл орон тооны туслах авч ажиллуулахгүйгээр түүнд зориулан батлагдсан төсвийг судалгаа, сурталчилгаа, мэдээллийн материал бэлтгүүлэх зориулалтаар ашиглаж болох бөгөөд энэ талаар Санхүү, үйлчилгээний хэлтэстэй урьдчилан тохиролцсон байна.

3.6.Гишүүний өөрийн төсвийг сар, улирлаар хуваарилах бөгөөд урьд олгогдсон төсвийн гүйцэтгэлийн санхүүгийн баримт, тайланг бүрэн гаргасны дараа тэдний бичгээр ирүүлсэн хүсэлтийг үндэслэн дараагийн сар, улирлын төсөвт зардлыг тухай бүрт нь олгоно.

3.7.Төсөвт зардлаа хэтрүүлэн зарцуулсан тохиолдолд илүү зарцуулсан зардлыг тухайн гишүүн болон бие төлөөлөгч-туслахаар бүрэн төлүүлнэ.

3.8.Энэ журмын 1.2.8-д заасан хотын дотор хэрэглэх унааны зардлыг дараахь байдлаар тооцож олгоно:

3.8.1.гишүүн өөрөө хүсэлт гаргасан тохиолдолд 1 км-ийг 300 төгрөгөөр тооцон ажлын

хоногт тогтоосон лимитийн зардлыг өөрт нь олгох;

3.8.2.унаа хэрэглэсэн тохиолдолд 1 км-ийг 300 төгрөгөөр тооцон хэмнэгдсэн лимитийн зардлыг өөрт нь олгох;

3.8.3.Байнгын хорооны дарга нэг сараас дээш хугацаагаар эзгүй байх тохиолдолд түүнийг албан ёсоор орлон ажилласан гишүүнд Байнгын хорооны даргын унааны лимитийн зөрүүг олгох.

3.9.Унаа хэрэглэсэн тухай гүйцэтгэлийн баримтыг үндэслэн унааны зардлын хэтрэлт, хэмнэлтийн тооцоог гаргаж тухайн гишүүнтэй тохиролцсоны дагуу дараа сарын 10-ны дотор багтаан хэтрэлт, хэмнэлтийн асуудлыг шийдвэрлэнэ.

3.10.Энэ журмын 1.2-т заасан гишүүний өөрийнх нь төсөвт зардлын цалингийн сангаас бусад зардлыг түүний зөвшөөрлөөр зөвхөн хоорондо нь шилжүүлэн зарцуулж болох бөгөөд өөр зүйлд зарцуулахыг хориглоно.

**Улсын Их Хурлын 2008 оны 28 дугаар тогтоолын 2 дугаар хавсралт**

## СОНГОГДСОН ТОЙРОГТОО ЖИЛД АЖИЛЛАХ УНААНЫ ЛИМИТ

| Тойрог | Тойргийн нэр | Сумын тоо | Аймгийн төв-сумдууд-аймгийн төв /км/ | Сумаас баг, суурин газруудад дунджаар 1 удаа 5 багт 30 км-ээр тооцов /км/ | Нэг удаа тойргийнхоо бүх сум, багуудаар явах км | Тойрогтоо ажиллах унааны нийт км |
|---|---|---|---|---|---|---|
| 1 | Архангай | 19 | 1533 | 2850 | 4383 | 8766 |
| 2 | Баян-Өлгий | 16 | 1466 | 2400 | 3866 | 7732 |
| 3 | Баянхонгор | 19 | 1547 | 2850 | 4397 | 8794 |
| 4 | Булган | 16 | 1665 | 2400 | 4065 | 8130 |
| 5 | Говь-Алтай | 19 | 1978 | 2850 | 4828 | 9656 |
| 6 | Дорноговь Говьсүмбэр | 18 | 1492 | 2700 | 4192 | 8384 |
| 7 | Дорнод | 14 | 1931 | 2100 | 4031 | 8062 |
| 8 | Дундговь | 15 | 1111 | 2250 | 3361 | 6722 |
| 9 | Завхан | 24 | 1768 | 3600 | 5368 | 10736 |
| 10 | Өвөрхангай | 19 | 1124 | 2850 | 3974 | 7948 |
| 11 | Өмнөговь | 15 | 1832 | 2250 | 4082 | 8164 |
| 12 | Сүхбаатар | 13 | 1183 | 1950 | 3133 | 6266 |
| 13 | Сэлэнгэ | 18 | 1618 | 2700 | 4318 | 8636 |
| 14 | Төв | 27 | 1809 | 4050 | 5859 | 11718 |
| 15 | Увс | 19 | 1731 | 2850 | 4581 | 9162 |
| 16 | Ховд | 17 | 1729 | 2550 | 4279 | 8558 |
| 17 | Хөвсгөл | 24 | 2112 | 3600 | 5712 | 11424 |
| 18 | Хэнтий | 17 | 1356 | 2550 | 3906 | 7812 |
| 19 | Дархан-Уул | 4 | 368 | 2400 | 2768 | 5536 |
| 20 | Орхон | 2 | 435 | 2250 | 2685 | 5370 |
| 21 | Хан-Уул, Багахангай, Багануур дүүрэг | | | | 1920 | 3840 |
| 22 | Баянзүрх, Налайх дүүрэг | | | | 1920 | 3840 |
| 23 | Сүхбаатар дүүрэг | | | | | |
| 24 | Чингэлтэй дүүрэг | | | | | |
| 25 | Баянгол дүүрэг | | | | | |
| 26 | Сонгинохайрхан дүүрэг | | | | | |
| | **ДҮН** | | 29788 | 54000 | 87628 | 175256 |

## МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2008 оны 05 дугаар сарын 16-ны өдөр | Дугаар 33 | Улаанбаатар хот

**Төрөөс олгох нэмэгдлийн хэмжээ тогтоох тухай**

Монгол Улсын баатар, хөдөлмөрийн баатар, ардын болон гавьяат цолтон ахмад настанд төрөөс олгох нэмэгдлийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 1 дэх хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1.Монгол Улсын баатар, хөдөлмөрийн баатар, ардын цолтон ахмад настанд төрөөс олгох нэмэгдлийн хэмжээг 200,000 /хоёр зуун мянга/, гавьяат цолтон ахмад настанд олгох нэмэгдлийн хэмжээг 150,000 /нэг зуун тавин мянга/ төгрөгөөр тус тус тогтоосугай.

2.Энэ арга хэмжээнд шаардагдах хөрөнгийг 2008 оны төсвийн тодотголд тусган шийдвэрлүүлэхийг Монгол Улсын Засгийн газар /С.Баяр/-т даалгасугай.

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА Д.ЛҮНДЭЭЖАНЦАН**

## МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2008 оны 05 дугаар сарын 16-ны өдөр | Дугаар 34 | Улаанбаатар хот

**Тогтоолын хавсралтад өөрчлөлт оруулах тухай**

Монгол Улсын Үндсэн хуулийн Тавин зургадугаар зүйлийн 3 дахь хэсэг, Прокурорын байгууллагын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1, 8.2 дахь хэсэгт заасныг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1.Прокурорын байгууллагын бүтэц, зохион байгуулалт, цалингийн санг тогтоох тухай Улсын Их Хурлын 1993 оны 7 дугаар сарын 9-ний өдрийн 59 дүгээр тогтоолын 2 дугаар хавсралтын 2 дахь хэсгийн 1 дэх заалтыг дор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

1/"Хоёр. Сум дундын прокурорын газар

| | | |
|---|---|---|
| 1.Завхан аймаг дахь сум дундын прокурорын газар | Тосонцэнгэл сум | Тосонцэнгэл, Асгат, Баянтэс, Баянхайрхан, Их-Уул, Нөмрөг, Түдэвтэй, Тэлмэн, Тэс сум" |

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА Д.ЛҮНДЭЭЖАНЦАН**

## МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2008 оны 05 дугаар сарын 16-ны өдөр | Дугаар 35 | Улаанбаатар хот

**Тогтоолын хавсралтад нэмэлт оруулах тухай**

Ойн тухай хуулийн 13.1 дэх хэсэгт заасныг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

Төрийн захиргааны байгууллагын тогтолцоо, бүтцийн ерөнхий бүдүүвчийг батлах тухай Улсын Их Хурлын 2004 оны 9 дүгээр сарын 22-ны өдрийн 14 дүгээр тогтоолын хавсралтын "Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг" гэсэн хэсэгт Байгаль орчны сайдын эрхлэх асуудлын хүрээнд "11. Ойн хэрэг эрхлэх газар" гэж нэмсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА Д.ЛҮНДЭЭЖАНЦАН**

## МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2008 оны 05 дугаар сарын 20-ны өдөр | Дугаар 38 | Улаанбаатар хот

**Үндсэн хуулийн цэцийн 2008 оны 06 дугаар дүгнэлтийн тухай**

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.3-ыг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1.Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.4-т "Нэр дэвшигч нь ... дараахь шаардлагыг хангасан байна" гээд 27.4.3-т "ялгүй байх" гэсэн нь Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 9 дэх хэсгийн "...төрийн байгууллагад сонгох, сонгогдох эрхтэй", Хорин нэгдүгээр зүйлийн 3-т "Улсын Их Хурлын гишүүнээр Монгол Улсын хорин таван нас хүрсэн, сонгуулийн эрх бүхий иргэнийг сонгоно" гэсэн заалтыг тус тус зөрчсөн байна гэсэн Үндсэн хуулийн цэцийн 2008 оны 5 дугаар сарын 14-ний өдрийн 06 дугаар дүгнэлтийг хүлээн зөвшөөрсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА Д.ЛҮНДЭЭЖАНЦАН**

## МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2008 оны 05 дугаар сарын 22-ны өдөр | Дугаар 44 | Улаанбаатар хот

**Монакогийн Хант Улстай дипломат харилцаа тогтоох тухай**

Монгол Улсын Үндсэн хуулийн Хорин тавдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 15 дахь заалтыг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

Монакогийн Хант Улстай дипломат харилцаа тогтоосугай.

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА Д.ЛҮНДЭЭЖАНЦАН**

## МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2008 оны 05 дугаар сарын 22-ны өдөр | Дугаар 45 | Улаанбаатар хот

**Тогтоолын хавсралтад нэмэлт оруулах тухай**

Засгийн газрын тухай хуулийн 12 дугаар зүйлийн 1 дэх хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1.Төрийн захиргааны байгууллагын тогтолцоо, бүтцийн ерөнхий бүдүүвчийг батлах тухай Улсын Их Хурлын 2004 оны 9 дүгээр сарын 22-ны өдрийн 14 дүгээр тогтоолын хавсралтаар баталсан Төрийн захиргааны байгууллагын тогтолцоо, бүтцийн ерөнхий бүдүүвчид дараахь агуулга бүхий заалт нэмсүгэй:

| | | |
|---|---|---|
| Ерөнхий сайдын эрхлэх ажлын үндсэн хүрээнд | 3[1]. Цөмийн энергийн комисс | |

2.Энэ тогтоолыг Цацрагийн хамгаалалт, аюулгүй байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА Д.ЛҮНДЭЭЖАНЦАН**

## МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2008 оны 05 дугаар сарын 22-ны өдөр | Дугаар 46 | Улаанбаатар хот

### Үндсэн хуулийн цэцийн гишүүний албан ажлын онцгой нөхцөлийн нэмэгдлийн хэмжээг шинэчлэн тогтоох тухай

Төрийн албаны тухай хуулийн 28.2.1, 28.7 дахь заалтыг тус тус үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1.Үндсэн хуулийн цэцийн гишүүний албан ажлын онцгой нөхцөлийн нэмэгдлийн хэмжээг албан тушаалын сарын цалингийн 30 хувиар тогтоож, 2008 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөхөөр тогтоосугай.

2.Энэ тогтоол батлагдсантай холбогдуулан "Үндсэн хуулийн цэцийн гишүүнд албан ажлын онцгой нөхцөлийн нэмэгдэл тогтоох тухай" Улсын Их Хурлын 1997 оны 6 дугаар сарын 5-ны өдрийн 40 дүгээр тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.

МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА Д.ЛҮНДЭЭЖАНЦАН

## МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2008 оны 02 дугаар сарын 27-ны өдөр | Дугаар 77 | Улаанбаатар хот

### Хаягжилтын нэгдсэн систем бий болгох тухай

Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. Солбицолд суурилсан код (Natural Area Code)-ыг ашиглан газар зүйн байрлалд тулгуурласан хаягжилтын нэгдсэн системийг Монгол Улсад бий болгох ажлыг 2008 оны 4 дүгээр сарын 1-нээс эхлүүлж түүнийг нэвтрүүлэхтэй холбогдсон аргачлал боловсруулж, мөрдүүлэх арга хэмжээ авахыг Хууль зүй, дотоод хэргийн сайд Ц.Мөнх-Оргил, Барилга, хот байгуулалтын сайд Ц.Цолмон нарт даалгасугай.

2. Солбицолд суурилсан код (NAC)-ыг хаягжуулалтын нэгдсэн систем болгон нэвтрүүлэхэд шаардлагатай зураг, өгөгдлөөр хангахыг Барилга, хот байгуулалтын сайд Ц.Цолмонд, газар зүйн солбицлын мэдээллийг хөрвүүлэн өгөгдлийн сан бүрдүүлэх арга хэмжээ авахыг Мэдээлэл, харилцаа холбоо, технологийн газрын дарга Ч.Сайханбилэгт тус тус даалгасугай.

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ САЙД С.БАЯР

МОНГОЛ УЛСЫН САЙД,
ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ
ЭРХЛЭХ ГАЗРЫН ДАРГА Н.ЭНХБОЛД

## МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2008 оны 02 дугаар сарын 27-ны өдөр | Дугаар 78 | Улаанбаатар хот

### Монгол Улсад бүртгэл, мэдээллийн нэгдсэн тогтолцоог бий болгох үндэсний хөтөлбөр батлах тухай

Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. "Монгол Улсад бүртгэл, мэдээллийн нэгдсэн тогтолцоог бий болгох үндэсний хөтөлбөр"-ийг 1 дүгээр хавсралтын, "Бүртгэлийн нэгдсэн тогтолцоог бий болгох үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө"-г 2 дугаар хавсралтын, "Монгол Улсад бүртгэлийн нэгдсэн тогтолцоог бий болгох үндэсний хөтөлбөрийн хүрээнд хэрэгжүүлэх тэргүүлэх ач холбогдол бүхий төсөл, арга хэмжээ"-г 3 дугаар хавсралтын ёсоор тус тус батлсугай.

2. Үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө болон хөтөлбөрийн тэргүүлэх ач холбогдол бүхий төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх ажлыг улсын хэмжээнд арга зүйн нэгдсэн удирдлага, зохион байгуулалтаар хангаж зохицуулж, хяналт тавьж

ажиллахыг Монгол Улсад бүртгэл, мэдээллийн нэгдсэн тогтолцоог бий болгох Үндэсний хороонд, хөтөлбөрт тусгагдсан арга хэмжээг хариуцсан чиглэл, заасан хугацаанд нь эрхлэх асуудлын хүрээ, орон нутгийн хэмжээнд хэрэгжүүлэхийг Засгийн газрын холбогдох гишүүд, бүх шатны Засаг дарга нарт тус тус даалгасугай.

3. Монгол Улсад бүртгэл, мэдээллийн нэгдсэн тогтолцоог бий болгох зорилгоор эрх зүйн орчин бүрдүүлэх ажлын хүрээнд шинээр болон шинэчлэн боловсруулах, нэмэлт, өөрчлөлт оруулах хууль тогтоомжийг зохих журмын дагуу боловсруулж батлуулах арга хэмжээ авахыг Хууль зүй, дотоод хэргийн сайд Ц.Мөнх-Оргилд даалгасугай.

4. Гадаадын зээл, тусламжийн хөрөнгөөр бүртгэл, мэдээллийн чиглэлээр хэрэгжүүлж байгаа төслийн үр ашгийг дээшлүүлж хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд чиглүүлэн хөтөлбөрт шаардагдах хөрөнгийг эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэл, жил бүрийн улсын төсөвт тусгах, гадаад, дотоодын байгууллага болон хувийн хөрөнгө оруулалт, санхүүгийн оролцоог нэмэгдүүлэх замаар санхүүжүүлэх арга хэмжээ авахыг Сангийн сайд Ч.Улаанд үүрэг болгосугай.

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ САЙД С.БАЯР

МОНГОЛ УЛСЫН САЙД,
ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ
ЭРХЛЭХ ГАЗРЫН ДАРГА Н.ЭНХБОЛД

**Засгийн газрын 2008 оны 78 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралт**

## МОНГОЛ УЛСАД БҮРТГЭЛИЙН НЭГДСЭН ТОГТОЛЦООГ БИЙ БОЛГОХ ҮНДЭСНИЙ ХӨТӨЛБӨР

### Нэг. Нийтлэг үндэслэл

Монгол Улсад зах зээлийн эдийн засгийн эхэн үед тулгамдаж байсан хүнд сорилтуудыг даван туулахад инфляцийг тогтворжуулах, үнэ тарифийн чөлөөлөх өмч хувьчлал, төсвийг тэнцвэржүүлэх зэрэг санхүүгийн салбарын эрүүл орчин бүрдүүлэхтэй холбоотой арга хэмжээнүүд томоохон үүрэг гүйцэтгэсэн.

Харин сүүлийн жилүүдийн эдийн засгийн тогтвортой өсөлт нь хүн амын амьжиргааны түвшин, нэг хүнд ногдох дотооодын нийт бүтээгдэхүүнд зэрэг өөрчлөлтийг бий болгосон боловч нэн ядуу болон ядуу иргэдийн тоо, далд эдийн засгийн хэмжээ буурахгүй, иргэдийн зүгээс газар хувьчилж авах байдал удаашралтай явагдаж байгаа зэрэг нь өмч хөрөнгийн бүртгэлийг төгөлдөршүүлэх замаар эдийн засгийн өсөлтөд дэмжлэг үзүүлэх хэрэгцээ байгааг харуулж байна.

Иргэний бүртгэлийн үйл ажиллагааны доголдлоос шалтгаалж тухайн иргэний талаархи мэдээлэл давхардах, зөрөх, орхигдох зэргээр үнэн, бодитой мэдээлэл гарч чадахгүй байна. Өнөөдөр Монгол Улсын нэг иргэн төрөл бүрийн үнэмлэх, дэвтэр, паспорт, гэрчилгээ, карт зэрэг 17 (хөнгөлөлтийн болон банкны картыг тооцохгүйгээр) нэр төрлийн бичиг баримтыг ашиглан эмнэлэг, эд хөрөнгийн эрхийн бүртгэл, нийгмийн даатгал, банк, санхүү, халамж, гааль, татвар, хууль хяналтын байгууллага зэрэг төрийн үйлчилгээ авах үйл ажиллагаанд оролцохдоо их хэмжээний хүнд сурталтай учирч байгаа билээ.

Засаг захиргааны нэгжид тулгуурласан хаягжилтын өнөөгийн байдал нь нэгдсэн стандарт, системгүй, ойлгомжгүй байгаа нь орчин үеийн бизнесийн үйлчилгээний шаардлага хангахгүй байна.

Хуулийн этгээдийн эрхийн бүртгэлийн үйл ажиллагааны эмх цэгцгүй байдал нь татвараас зайлсхийх, эрхийн бүртгэл давхардах, хууран мэхлэх, бизнесийн үйл ажиллагаанд сөрөг нөлөө үзүүлэх, авлига хээл хахуулийг өөгшүүлэх нөхцөл байдлыг үүсгэж байна.

Монгол Улс Үндсэн хуулиараа эдийн засгийн эрх чөлөө, хувийн өмч, эд хөрөнгийн халдашгүй эрхийг тунхагласан боловч бодит амьдралд өмчийн албан ёсны бүртгэлийн тогтолцоо бүрэн гүйцэд төгөлдөршөөгүйгээс хөрөнгийн тоо хэмжээ, зах зээлийн үнэлэмж тодорхойгүй, хөрөнгийн арилжаа баталгаагүй байна. Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэл нь асар их мэдээлэл агуулж байдаг учраас эрхийн улсын бүртгэлийн мэдээллийн баазын даац хэтрэх, хандах хэрэглэгчийн тоо нэмэгдсэнээс мэдээлэл боловсруулах процессын үйлдлүүд удаашрах зэрэг бэрхшээл гарч байна.

Иргэний бүртгэл, хуулийн этгээдийн улсын бүртгэл, эд хөрөнгийн эрхийн бүртгэл, төр, захиргаа, нийгмийн даатгал, гааль, татвар, цагдаа, хил хамгаалах зэрэг байгууллагын бүртгэл, мэдээллийн сангууд нь салангид, хоорондоо хөрвөх боломжгүй, харилцан холбогдоогүй байгаа

нь төрийн үйлчилгээг иргэдэд шуурхай хүргэхэд бэрхшээл учруулж, төр иргэн хоорондын харилцааг холдуулах, хүнд суртал газар авах, улмаар далд эдийн засаг, авлигын суурь хөрсийг бэхжүүлж, эдийн засгийн хөгжилд сөргөөр нөлөөлж байна.

Иймд даяарчлагдан хөгжиж байгаа өнөөгийн орчинд өөрийн орны хөгжлийг урьдчилан харсан бодлого, стратеги боловсруулж хэрэгжүүлэхэд нэгдсэн бүртгэл, мэдээллийн бааз суурь дээр тулгуурласан төрийн нэгдмэл бодлого нэн чухал байна.

Төрийн үйлчилгээний байгууллагууд мэдээллээ тус тусдаа бүрдүүлж, харилцан уялдаагүй мэдээллийн сангуудад хадгалж, үйлчилгээ үзүүлж байгаа явдлыг арилгаж, төрийн ой санамжийг бэхжүүлэх зорилгоор Монгол Улсад бүртгэлийн нэгдсэн тогтолцоог бий болгох үндэсний хөтөлбөрийг боловсруулж байна.

Дэлхийн хөгжингүй улс орон өөрийн Засгийн газрын үйл ажиллагааг оновчтой болгох, төрийн байгууллагуудын хоорондын уялдаа холбоог нягтруулах, иргэдэд төрийн зүгээс үзүүлэх үйлчилгээг сайжруулах зорилгоор бүртгэлийн нэгдсэн тогтолцоог бүрдүүлэхдээ мэдээлэл, харилцаа холбооны технологийн ололтыг ашиглах нь чухал ач холбогдолтой гэж үзэж энэ чиглэлээр төрөл бүрийн бодлого, хөтөлбөр, төслүүдийг хэрэгжүүлж байна. Тухайлбал, Австри Улс 2001 оноос "Digitales Osterreich", Бүгд Найрамдах Солонгос Улс 1997 оноос "E-Government", "U-Korea", Холбооны Бүгд Найрамдах Герман Улс 2003 оноос "Deutschland-Online" хөтөлбөрүүдийг хэрэгжүүлж иржээ. Европын холбооноос бүртгэлийн нэгдсэн тогтолцоог бүрдүүлэх INSPIRE нэртэй хөтөлбөрийг 2013 он хүртэл 3 үе шаттай хэрэгжүүлэхээр ажиллаж байна.

Улсын Их Хурлын 2000 оны 21 дүгээр тогтоолоор батлагдсан "Мэдээлэл, холбооны технологийг 2010 он хүртэл хөгжүүлэх үзэл баримтлал", Улсын Их Хурлын 2005 оны 25 дугаар тогтоолоор батлагдсан "Монгол Улсын Мянганы хөгжлийн зорилт", Засгийн газрын 2005 оны 216 дугаар тогтоолоор батлагдсан "Цахим Монгол" Үндэсний хөтөлбөр зэрэг бодлогын баримт бичигт бүртгэлийн нэгдсэн тогтолцоог бий болгоход мэдээлэл, холбооны технологийн давуу тал, ололтыг ашиглах үндэслэл нь тусгагдсан байна.

Хөтөлбөрийг хэрэгжүүлснээр бүртгэлийн нэгдсэн тогтолцооны шинэ эрх зүйн орчин, мэдээллийн сан, техник технологийн дэд бүтцийг бүрдүүлж, хүн амын бүртгэл, эд хөрөнгийн эрхийн бүртгэл боловсронгуй болж эд хөрөнгийн эдийн засгийн эргэлтийг нэмэгдүүлэх, гадаадын иргэдийн шилжилт хөдөлгөөний бодит тоо хэмжээг тодорхойлох, хяналт тавих, түүнчлэн иргэн, хуулийн этгээд, эд хөрөнгийн эрхийн бүртгэл, тооллогын талаарх мэдээлэл нь үнэн зөв, бодитой болно.

Хөтөлбөрийн үр дүнд төрийн үйлчилгээг иргэдэд шуурхай хүртээх, ил тод авлигагүй тогтолцоог бүрдүүлэх, төгөлдөршүүлэх, суурь болон төрөлжсөн мэдээллийн санг ашиглан байршил, эзэмшилт, ашиглалт, арилжаа, солилцооны чөлөөт байдалд тулгуурласан, зах зээлийн бодит үнэлгээгээр үнэлэгдсэн эд хөрөнгийг баталгаажуулах юм. Ингэснээр хөрөнгийн чадамжийг өсгөх, банк, санхүү, даатгалын системийн эргэлт нэмэгдэх, хөдөлмөрийн хуваарь сайжрах, төр, хувийн хэвшил, иргэдийн хоорондын харилцаа, түншлэлийг бүрдүүлэх замаар үндэсний аюулгүй байдлыг баталгаажуулах ач холбогдолтой.

**Хоёр. Хөтөлбөрийн зорилго**

2.1. Хөтөлбөрийн үндсэн зорилго нь Монгол Улсад бүртгэлийн нэгдсэн тогтолцоог бий болгох замаар төрийн бодлогын нэгдмэл чанарыг хангах, үндэсний аюулгүй байдлыг бэхжүүлэх, улс орны эдийн засгийн өсөлтөд дэмжлэг үзүүлэх, төрийн ой санамжийг бүрдүүлэх, төрөөс иргэд болон бизнесийн байгууллагад үзүүлэх нийгмийн бүх салбарыг хамарсан үйлчилгээг хүртээмжтэй, шуурхай, үр ашигтай болгож хүнд суртал, авлигатай тэмцэхэд бодитой хувь нэмэр оруулахад оршино.

**Гурав. Хөтөлбөрийн хамрах хүрээ, бүрэлдэхүүн, хэрэгжүүлэх үндсэн зарчим**

3.1. Монгол Улсын бүртгэлийн нэгдсэн тогтолцоо бий болгох Үндэсний хөтөлбөрт төр, захиргааны бүх шатны болон нутгийн удирдлагын байгууллагын мэдээ, мэдээллийн сан, тэдгээрийг удирдах мэдээллийн систем болон дэд бүтэц, мэдээллийн санг бүрдүүлэх, ашиглахтай холбоотой хууль тогтоомж, стандарт, дүрэм, журам, заавар, бүртгэлийн нэгдсэн тогтолцоо, түүний удирдлагыг бий болгоход чиглэсэн төсөл, арга хэмжээ хамаарна.

**Дөрөв. Бүртгэлийн нэгдсэн тогтолцооны бүрэлдэхүүн хэсгүүд**

4.1. Монгол Улсын бүртгэлийн нэгдсэн тогтолцоо нь дараахь үндсэн бүрэлдэхүүн хэсгүүдээс бүрдэнэ:

Монгол Улсын бүртгэлийн нэгдсэн тогтолцоо




Зураг 6.1
Зураг-1. Бүртгэлийн нэгдсэн тогтолцооны бүрэлдэхүүн хэсгүүд

4.1.1. хууль, тогтоомж, дүрэм, журам, стандарт, хаягжилтын нэгдсэн систем;

4.1.2. бүртгэлийн тогтолцооны нэгдмэл удирдлага (газар зүйн мэдээллийн системд үндэслэсэн (GIS) орон зайн мэдээллийн санд тулгуурласан байх;

4.1.3. Монгол Улсын бүртгэлийн нэгдсэн мэдээллийн сан, түүнийг бүрдүүлэгч, хэрэглэгч байгууллагууд;

4.1.4. бүртгэлийн нэгдсэн мэдээллийн дэд бүтэц;

4.1.5. хүний нөөцийн чадавхи.

4.2. Хууль тогтоомж, эрх зүйн орчин: Бүртгэлийн нэгдсэн тогтолцоо бүрдүүлэх, түүний тогтвортой ажиллагааг дэмжих, мэдээллийн санг ашиглах, мэдээлэл харилцан солилцох нөхцөл шаардлагыг хангахад чиглэсэн хууль, тогтоомж, дүрэм, журам, стандартыг боловсруулах, холбогдох хууль тогтоомжид нэмэлт, өөрчлөлт оруулж эрх зүйн таатай орчинг бүрдүүлнэ.

4.3. Бүртгэлийн нэгдмэл удирдлага: Хууль тогтоомжийн хүрээнд бүртгэлийн нэгдмэл тогтолцооны удирдлага, зохион байгуулалтыг хэрэгжүүлэх бүтэц, удирдлагыг бий болгоно.

4.4. Мэдээллийн сан, түүнийг бүрдүүлэгч, хэрэглэгч: Мэдээллийн санг бүрдүүлэгч нь бүртгэлийн чиг үүрэг бүхий төрийн байгууллага, суурь, төрөлжсөн, төрийн байгууллагын мэдээллийн санг үүсгэгчид байх бөгөөд хэрэглэгч нь төрийн байгууллага, аж ахуйн нэгж, байгууллага, иргэд, төрийн бус байгууллага байна.

4.5. Мэдээлэл, харилцаа холбооны дэд бүтэц: Монгол Улсын бүртгэлийн нэгдсэн тогтолцоог хэрэгжүүлэхэд шаардагдах программм, техник хангамж, мэдээллийн технологийн ашиглалт, үйлчилгээний нэгдмэл байдал, мэдээллийн сан, сүлжээний аюулгүй байдлыг хангасан мэдээлэл, харилцаа холбооны дэд бүтэц байна.

4.6. Хүний нөөцийн чадавхи: Бүртгэлийн нэгдсэн тогтолцоог бий болгох, тогтвортой ажиллагааг хангахад шаардлагатай мэргэжилтэй боловсон хүчин бэлтгэх, чадавхийг бүрдүүлэх, төрийн албан хаагчдын мэргэжил, ур чадварыг дээшлүүлэх, иргэдийн зүгээс цахим үйлчилгээ, хэрэглээг хүртэх чадамжийг бүрдүүлнэ.

4.7. Бүртгэлийн нэгдсэн тогтолцооны бүтэц, архитектур нь төрийн байгууллагаас иргэд, байгууллагад үзүүлэх төрийн үйлчилгээг ил тод болгох, шуурхай хүргэх, оролцоог хангах бүтэц, зохион байгуулалт, бизнес процессын үйл ажиллагаа, программ хангамж болон мэдээллийн агуулга, вэб портал, бүртгэл мэдээллийн санг бүрдүүлэх, мэдээлэл, холбооны сүлжээ, дэд бүтэц, мэдээллийн нэгдсэн төвөөс технологи, үйлчилгээ, ашиглалт, арга зүйн зөвлөгөө өгөх цогц орчинг тодорхойлсон төрийн байгууллага, иргэд, хувийн хэвшлийн хамтын ажиллагаанд суурилсан байна.

4.8. Монгол Улсын бүртгэлийн нэгдсэн тогтолцоо нь бүртгэл, мэдээллийн асуудлыг хариуцсан байгууллагаар дамжуулан яам, Засгийн газрын агентлаг, холбогдох төрийн байгууллага бүртгэл, мэдээллийн нэгдсэн сан үүсгэх, хоорондоо бүртгэл, мэдээллээ харилцан солилцох замаар иргэд, байгууллагад төрийн бүх төрлийн үйлчилгээг хүргэхээр зохион байгуулагдана.

**Тав. Мэдээллийн сангийн ангилал**

5.1. Хөтөлбөрийн хүрээнд мэдээллийн сангийн төрөл, ангилал, тэдгээрийг бүрдүүлэх чиг үүрэг бүхий байгууллага, бүтцийг бий болгоно. Монгол Улсын бүртгэлийн нэгдсэн мэдээллийн сан нь дараахь үндсэн ангилалд хуваагдах бөгөөд эдгээр бүртгэл, мэдээллийн сан нь орон зайн мэдээллийн санд тулгуурласан байна:

а/ суурь буюу эрх зүйн бүртгэлийн мэдээллийн сан;
б/ төрөлжсөн бүртгэлийн мэдээллийн сан;
в/ төрийн байгууллагуудын мэдээллийн сан.

5.1.1. Орон зайн мэдээллийн сан нь дараахь мэдээллүүдээс бүрдэнэ:

а/ геодезийн тулгуур сүлжээний цэгүүдийн мэдээлэл;
б/ агаар, сансрын зураг;
в/ бүх масштабын байр зүйн зураг;
г/ газар зүйн нэр;
д/ засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн хилийн цэсийн зураг;
е/ авто болон төмөр замын байршлын зураг болон бусад мэдээлэл;
ж/ ус зүйтэй холбоотой мэдээлэл;
з/ газар доорхи шугам сүлжээний мэдээлэл;
и/ газрын улсын кадастрын зураг болон бүртгэлийн мэдээлэл;
к/ газрын нэгдмэл сангийн зураг болон тоо, бүртгэлийн мэдээлэл;
л/ газар зохион байгуулалтын төлөвлөлтийн зураг, мэдээлэл.

5.2. Суурь буюу эрх зүйн бүртгэлийн мэдээллийн сан нь дараахь төрөл, ангилалд хуваагдана:

5.2.1. иргэний бүртгэлийн мэдээллийн сан;

5.2.2. эд хөрөнгийн улсын бүртгэлийн эрхийн бүртгэлийн мэдээллийн сан;

5.2.3. хуулийн этгээд болон үйл ажиллагааны эрхийн бүртгэлийн мэдээллийн сан.

5.3. Иргэний бүртгэлийн мэдээллийн сангийн иж бүрдэл;

5.3.1. иргэний гэр бүлийн байдлын бүртгэл:

а/ хүн амын регистрийн мэдээллийн сан;
б/ төрөлтийн мэдээллийн сан;
в/ хүүхэд үрчилсэн тухай мэдээллийн сан;
г/ овог, нэр өөрчилсөн тухай мэдээллийн сан;
д/ эцэг тогтоосон тухай мэдээллийн сан;
е/ гэрлэсний, гэрлэлт сэргээсэн тухай мэдээллийн сан;
ж/ гэрлэлт цуцлуулсан тухай мэдээллийн сан;
з/ нас барсан тухай мэдээллийн сан.

5.3.2. дотоод шилжих хөдөлгөөний бүртгэл:
а/ нэг аймаг, хотоос нөгөө аймаг, хот руу шилжин явсан тухай мэдээллийн сан;
б/ аймаг, хотод шилжин ирсэн тухай мэдээллийн сан;
в/ аймаг, хот дотроо шилжсэн тухай мэдээллийн сан.

5.3.3. гадаад шилжих хөдөлгөөний бүртгэл:
а/ Монгол Улсаас гадаад оронд оршин суухаар явсан тухай мэдээллийн сан;
б/ Монгол Улсаас гадаад оронд удаан хугацаагаар ажиллахаар явсан тухай мэдээллийн сан;
в/ Монгол Улсаас гадаад оронд удаан хугацаагаар суралцахаар явсан тухай мэдээллийн сан;
г/ Монгол Улсаас гадаад оронд түр хугацаагаар зорчихоор яваад буцаж ирээгүй тухай мэдээллийн сан.

5.3.4. иргэний үнэмлэхийн бүртгэл:
а/ иргэний үнэмлэх олголтын мэдээллийн сан;
б/ иргэний үнэмлэх хүчингүй болгосон мэдээллийн сан.

5.3.5. гадаад паспортын бүртгэл:

а/ гадаад паспорт олголтын мэдээллийн сан;
б/ хүчингүй болсон гадаад паспортын мэдээллийн сан;
в/ зорчилтэй иргэдэд хориг тавьсан тухай мэдээллийн сан;
г/ хориг цуцалсан тухай мэдээллийн сан;
д/ хүүхдийн хавсралтын мэдээллийн сан;
е/ Монгол Улсын харьяатаас гарсан тухай мэдээллийн сан;
ж/ Монгол Улсын харьяат болсон тухай мэдээллийн сан;
з/ харьяатаа сэргээлгэсэн тухай мэдээллийн сан.

5.3.6. архивын лавлагааны бүртгэл:

а/ иргэний гэр бүлийн лавлагааны мэдээллийн сангууд (нийт 8 төрлийн лавлагааны мэдээллийн сан).

5.4. Эд хөрөнгийн улсын бүртгэлийн эрхийн бүртгэлийн мэдээллийн сан:

5.4.1. газар өмчлөх, эзэмших, ашиглах эрхийн бүртгэл:
а/ анхны бүртгэл, баталгаажуулалт;
б/ гэрээний эрхийн бүртгэл.

5.4.2. үл хөдлөх эд хөрөнгө өмчлөх, эзэмших, ашиглах эрхийн бүртгэл:

а/ анхны бүртгэл, баталгаажуулалт;
б/ гэрээний эрхийн бүртгэл.

5.4.3. хөдлөх эд хөрөнгө өмчлөх, эзэмших, ашиглах эрхийн бүртгэл:

а/ анхны бүртгэл, баталгаажуулалт;
б/ гэрээний эрхийн бүртгэл.

5.4.4. хууль хяналтын байгууллагуудад өгөх мэдээлэл,тайлбар, лавлагааны бүртгэл:

а/ иргэн, хуулийн этгээдэд өгөх лавлагааны бүртгэл;
б/ эд хөрөнгө өмчлөх эрхийн улсын бүртгэлд орсон өөрчлөлт, хөдөлгөөн баяжилтын бүртгэл;
в/ өв, залгамжлал, гэрээ гэрээслэлийн эрхийн бүртгэл;
г/ тухайн эд хөрөнгөтэй холбоотой ирсэн болон явсан бичиг, өргөдөл, гомдол, хүсэлт тэдгээрт хариу өгсөн бүртгэл;
д/ шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн үйл ажиллагааны бүртгэл;
е/ ашигт малтмал эзэмших, ашиглах эрхийн бүртгэл;
ж/ үнэт цаас, лизингийн эрхийн бүртгэл.

5.5. Хуулийн этгээд болон үйл ажиллагааны эрхийн бүртгэлийн мэдээллийн сан:

а/ үүсгэн байгуулсан, өөрчлөн байгуулсан, татан буулгасан бүртгэл;
б/ хаяг, байршил, шилжилт хөдөлгөөн;
в/ үйл ажиллагааны чиглэл;
г/ банк зээлийн түүх;
д/ татвар төлөлт;
е/ даатгалын мэдээлэл;
ж/ жижиг, дунд үйлдвэр эрхлэгч иргэн, хуулийн этгээдийн бүртгэл.

5.6. Төрөлжсөн бүртгэлийн мэдээллийн сангууд:

5.6.1. Монгол банкны мэдээллийн сан:

а/ зээлийн мэдээллийн сан;
б/ банк хоорондын төлбөр тооцооны мэдээллийн сан;
в/ Төв банкны үнэт цаасны мэдээллийн сан.

5.6.2.татварын мэдээллийн сан:

а/ хуулийн этгээдийн бүртгэлийн сан;
б/ татвар төлөгч аж ахуйн нэгжийн бүртгэлийн сан;
в/ татвар төлөгч иргэний бүртгэлийн сан;
г/ хөрөнгийн бүртгэлийн сан:
- үл хөдлөх эд хөрөнгийн бүртгэлийн сан;
- автотээврийн болон өөрөө явагч хэрэгслийн бүртгэлийн сан;
- бууны бүртгэлийн сан;
- мал бүхий иргэний бүртгэлийн сан;
д/ татварын тайлангийн ногдлын бүртгэлийн сан;
е/ татвар төлөлтийн бүртгэлийн сан;
ж/ татварын өрийн бүртгэлийн сан;
з/ татвар төлөгчдийн талаархи хөндлөнгийн мэдээллийн бүртгэлийн сан.

5.6.3. гаалийн мэдээллийн сан;
5.6.4. оюуны өмч, оюуны үнэт зүйлийн мэдээллийн сан;
5.6.5. үндэсний архивын мэдээллийн сан;
5.6.6. нийгмийн даатгалын мэдээллийн сан;
5.6.7. нийгмийн хамгааллын мэдээллийн сан;
5.6.8. эрүүл мэндийн мэдээллийн сан;
5.6.9. боловсролын мэдээллийн сан;
5.6.10. мал аж ахуйн мэдээллийн сан;
5.6.11. газар тариалангийн мэдээллийн сан;
5.6.12. гадаадын зээл, тусламжийн мэдээллийн сан;
5.6.13. автомашин, тээврийн хэрэгслийн мэдээллийн сан;
5.6.14. жолооны эрхийн мэдээллийн сан;
5.6.15. байгалийн нөөцийн мэдээллийн сан;
5.6.16. түүх, соёл, урлаг, дурсгалт зүйлийн мэдээллийн сан;
5.6.17. гамшгийн мэдээллийн сан;
5.6.18. ус, усны нөөцийн мэдээллийн сан;
5.6.19. байгаль орчин, цаг уурын мэдээллийн сан;
5.6.20. газар зүйн мэдээллийн сан;

5.6.21. стандартын мэдээллийн сан;
5.6.22. уул уурхай, ашигт малтмал, геологи хайгуулын мэдээллийн сан;
5.6.23. дэд бүтцийн төрөлжсөн мэдээллийн сан;
5.6.24. гадаадын иргэд, цагаачдын мэдээллийн сан;
5.6.25. хил хамгаалалтын мэдээллийн сан;
5.6.26. батлан хамгаалахын мэдээллийн сан;
5.6.27. цэргийн бүртгэлийн мэдээллийн сан;
5.6.28. шүүх, цагдаагийн мэдээллийн сан;
5.6.29. хөдөлмөр эрхлэлт, ажил мэргэжлийн мэдээллийн сан;
5.6.30. банк, зээлийн түүхийн мэдээллийн сан;
5.6.31. бусад.

5.7. Төрийн байгууллагын мэдээллийн сангууд:

5.7.1. хууль тогтоомжийн нэгдсэн сан;
5.7.2. төрийн албан хаагчдын мэдээллийн сан;
5.7.3. төрийн болон орон нутгийн өмч, хөрөнгийн мэдээллийн сан;
5.7.4. төрийн нууцын мэдээллийн сан;
5.7.5. төрийн захиргааны байгууллагуудын мэдээллийн сан;
5.7.6. төрийн байгууллагуудын худалдан авалтын мэдээллийн сан;
5.7.7. нийслэл, аймаг, дүүргийн төрийн байгууллагуудын мэдээллийн сан;
5.7.8. төрийн портал;
5.7.9. бусад.

**Зургаа. Хэрэгжүүлэх үндсэн зарчмууд**

6.1. Бүртгэлийн нэгдсэн тогтолцоог бий болгох зорилтыг хэрэгжүүлэхэд холбогдох хууль тогтоомжид нэмэлт, өөрчлөлт оруулах шинээр боловсруулан батлуулах, мэдээллийн технологийн ололтод суурилсан дэд бүтцийг байгуулах, төрийн болон нутгийн удирдлагын бүх шатны байгууллагыг өргөнөөр хамруулах, төр болон хувийн хэвшлийн түншлэлд түшиглэх, иргэдийн оролцоог хангах, бүх нийтийн мэдээллийн технологийн мэдлэг боловсролыг дээшлүүлэх, сургалт, сурталчилгаа зохион байгуулахад тулгуурлана.

6.2. Монгол Улсын бүртгэлийн нэгдсэн мэдээллийн сан нь төрийн болон иргэд, хуулийн этгээдтэй хамааралтай мэдээллийн сангаас бүрдэнэ.

6.3.Хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд дараахь үндсэн зарчмыг баримтална:

6.3.1. төрийн болон нутгийн удирдлагын бүх шатны байгууллагуудын оролцоо, удирдлага, манлайллыг өргөжүүлэх;

6.3.2. төр, хувийн хэвшлийн түншлэл, үр ашигтай хамтын ажиллагаанд тулгуурлах;

6.3.3. иргэд, олон нийтийн идэвхи, оролцоог өргөтгөх;

6.3.4. хөтөлбөрийн хүрээнд зохион байгуулах арга хэмжээний ач холбогдол, үр өгөөжийг олон нийтэд сурталчлах;

6.3.5. мэргэжлийн боловсон хүчний хангамжийг сайжруулах, тогтвор суурьшилтай ажиллах нөхцөл боломжийг дээшлүүлэх;

6.3.6. төрийн байгууллагуудын ажлын уялдаа холбоог дээшлүүлэх.

**Долоо. Хөтөлбөрийн зорилт, хүрэх үр дүн, хэрэгжүүлэх үйл ажиллагаа**

Хөтөлбөрийн үндсэн зорилгыг биелүүлэхийн тулд дараахь зорилтуудыг дэвшүүлж тэдгээрийн үйл ажиллагааны хүрээ, хүрэх үр дүнг тодорхойлж байна.

7.1. Стратегийн нэгдүгээр зорилтын хүрээнд бүртгэлийн нэгдсэн тогтолцооны эрх зүйн орчинг бүрдүүлэх зорилгоор Монгол Улсад хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа хууль, эрх зүйн баримт бичиг, дүрэм, журмыг шинэчлэх, бүртгэлийн нэгдсэн тогтолцооны эрх зүйн орчинг бүрдүүлнэ.

7.2. Хүрэх үр дүн. Хууль эрх зүй, зохицуулалтын таатай орчин бүрдэнэ.

7.3. Үйл ажиллагааны хүрээ: Бүртгэлийн ерөнхий болон бусад тулгуур хуулийн төслийг шинээр боловсруулж, батлуулах:

а/ бүртгэлийн талаархи ерөнхий хууль;
б/ хөдлөх эд хөрөнгийн барьцааны эрхийн бүртгэлийн талаархи хууль
в/ цахим гарын үсгийн талаархи хууль;
г/ мэдээллийн аюулгүй байдлын талаархи хууль;
д/ газар зүй, орон зайн мэдээллийн талаархи хууль.

7.4. Бүртгэлийн нэгдсэн тогтолцоонд шилжихэд шаардлагатай хууль тогтоомжийг шинэчлэн боловсруулж, батлуулах:

а/ Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хууль;

б/ Эд хөрөнгө өмчлөх эрх түүнтэй холбоотой эд хөрөнгийн бусад эрхийн улсын бүртгэлийн тухай хууль;

в/ Харилцаа холбооны тухай хууль;
г/ Татварын ерөнхий хууль;

д/ Кадастрын зураглал ба газрын кадастрын тухай хууль;

е/ Газрын тухай хууль;

Нэмэлт, өөрчлөлт оруулах хуулиуд:

а/ Жижиг, дунд үйлдвэрийн тухай хууль

б/ Иргэний хууль /цахим хэлцлийн талаар/

в/ Статистикийн тухай хууль;

г/ Иргэний бүртгэлийн тухай хууль;

к/ бусад.

7.5. Зарим хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах, хууль тогтоомжид нийцүүлэн холбогдох дүрэм, журам боловсруулж, батлуулах.

7.6. Бүртгэл, мэдээллийн ангилал, бүтцийг тодорхойлон түүнд хандах эрхийн түвшинг хууль, дүрэм, журмаар тогтоох.

7.7. Бүртгэл, мэдээллийн технологийн ажилтны ажлын байрны тодорхойлолт, эрх үүрэг, цалин хөлсний тогтолцоог боловсронгуй болгох.

7.8. Бүртгэл, мэдээллийн сангуудын ангилал, нэр төрлийг хянан үзэж, төрийн үйл ажиллагаанд зайлшгүй шаардлагатай бусад мэдээллийн санг бий болгох.

7.9. Тэргүүн ээлжинд ашиглах стандартын жагсаалт гаргах, боловсруулан батлуулах.

7.10. Стратегийн хоёрдугаар зорилтын хүрээнд бүртгэлийн нэгдсэн тогтолцоонд баримтлах стандарт, техник технологи, нийтлэг ангилал, нэгдсэн код, дүрэм журам, хаягжилтын системийг бүрдүүлнэ.

7.11. Хүрэх үр дүн: Бүртгэлийн нэгдсэн тогтолцооны суурь дүрэм, журам, стандарт, хаягжилтын систем, тогтолцоо бүрдэнэ.

7.12. Үйл ажиллагааны хүрээ:

7.12.1. бүртгэлийн нэгдсэн тогтолцооны архитектурыг боловсруулан батлах;

7.12.2. хаягжуулалтын нэгдсэн шинэ систем бий болгох, хэрэгжилтийг зохион байгуулах;

7.12.3. мэдээллийн аюулгүй байдлын олон улсын стандартыг боловсруулан батлуулж мөрдүүлэх, удирдлага арга зүйгээр хангах;

7.12.4. бүртгэл, мэдээллийн нэгдсэн тогтолцоонд хамрагдах мэдээллийн үзүүлэлтүүдийн тодорхойлолт, цуглуулах аргачлал, хэрэглэгдэх нэгдсэн код, стандарт, ангиллын тогтолцоог статистикийн төв байгууллагаар баталгаажуулан хэрэгжүүлэх;

7.12.5. нэгдсэн сүлжээнд ашиглагдах сүлжээний болон хэрэглэгчийн тоног, төхөөрөмжийн нөхцөл, шаардлагыг тогтоож, баталгаажуулалтын тогтолцоог бий болгоно;

7.12.6. бүртгэлийн нэгдсэн тогтолцооны техник, технологийн суурь, нэгдсэн стандартыг боловсруулж хэрэгжүүлэх, хэрэгжилтэд хяналт тавихтай холбоотой дүрэм, журмыг батлуулах;

7.12.7. латин үсгийн галигчлалын нэгдмэл стандарт, кирилл үсгийн юникодыг боловсронгуй болгох;

7.12.8. зип кодыг нэвтрүүлэх ажлыг дэмжих, хэрэглээний талаар сургалт, сурталчилгаа хийх;

7.12.9. засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн кодыг боловсронгуй болгон хэрэгжүүлэх;

7.12.10. орон зайн мэдээллийн сангийн суурь болон холбогдох стандартыг батлуулах, хэрэглээнд нэвтрүүлэх.

7.13. Стратегийн гуравдугаар зорилтын хүрээнд суурь, төрөлжсөн, төр захиргааны байгууллагуудын мэдээллийн санг бүрдүүлэх, бүртгэлийн тогтолцооны мэдээллийн сүлжээ, дэд бүтцийг байгуулах, иргэний ухаалаг үнэмлэх олгоно.

7.14. Хүрэх үр дүн: Бүртгэлийн нэгдсэн тогтолцооны удирдлага зохион байгуулалтын бүтэц, мэдээллийн сан, дэд бүтцийг бүрдүүлнэ.

7.15. Үйл ажиллагааны хүрээ:

7.15.1. үндсэний өгөгдөл мэдээллийн төвийг байгуулах, холбогдох байгууллагуудын бүртгэлийн мэдээллийг байршуулах, статистикийн төв байгууллагатай бүртгэл, мэдээллийг солилцох төлөвлөгөөг боловсруулж, хэрэгжүүлэх;

7.15.2. Монгол Улсын иргэний эрхийг баталгаажуулах, төрийн үйлчилгээ, хэрэглээг

хүртэх иргэний үнэмлэхийг бий болгож, Монгол Улсын иргэдэд олгох арга хэмжээг үе шаттай хэрэгжүүлэх;

7.15.3. орон зайн мэдээллийн нэгдсэн санг бүрдүүлэх, суурь болон бусад мэдээллийн сантай уялдуулах;

7.15.4. иргэний бүртгэл, иргэний үнэмлэх, паспорт хяналтын нэгдсэн сүлжээг иж бүрэн болгон хэрэгжүүлэх;

7.15.5. иргэний бүртгэл, мэдээллийн улсын нэгдсэн сүлжээний төслийг хэрэгжүүлж, эхний ээлжинд аймаг, нийслэл, дүүргийн бүртгэлийн үйл ажиллагааг "онлайн" сүлжээнд холбох;

7.15.6. үндэсний өгөгдөл мэдээллийн төвийн нөөцийн системийг Улаанбаатар хотоос гадна байгуулах, дэд бүтцийн асуудлыг шийдвэрлэх, өгөгдөл мэдээллийн нөөц сан бий болгох ажлыг зохион байгуулах;

7.15.7. үндэсний өгөгдөл мэдээллийн төв, төрийн захиргааны төв байгууллага, агентлаг, холбогдох аж ахуйн нэгж байгууллагыг холбосон өндөр хурдны шилэн кабелийн интранет сүлжээг байгуулж, ашиглалтад оруулах;

7.15.8. бүртгэлийн тогтолцоог бүрдүүлэх программм хангамжийг лицензтэй, боловсронгуй болгох, мэдээллийн системийн харилцан уялдаа, мэдээллийн аюулгүй байдлыг хангах;

7.15.9. архивын болон цаасан хэлбэрийн мэдээллийн санг цахим хэлбэрт хөрвүүлэх, бүртгэлийн нэгдсэн санд нэгтгэх;

7.15.10. нийслэлд төр, захиргааны байгууллага, дүүрэг, хороо, цэцэрлэг, сургууль, эмнэлгийг өндөр хурдны сүлжээгээр холбох, нийслэлийн бүртгэл мэдээллийн солилцооны дэд бүтцийг боловсронгуй болгох;

7.15.11. аймаг, дүүрэг, сум, хороонд үндэсний бүртгэлийн нэгдсэн интранет сүлжээ ашиглах боломжийг бүрдүүлэх;

7.15.12. Үндэсний орон зайн мэдээллийн дэд бүтэц байгуулах, мэдээлийн сан бүрдүүлэх, программм хангамжийг боловсронгуй болгох талаар хэрэгжүүлж байгаа болон хэрэгжүүлэх төсөл, хөтөлбөрүүдийн уялдаа холбоог сайжруулах;

7.15.13. бүртгэл, мэдээллийн удирдлагын тогтолцоог шинэчлэх, хөдөө орон нутагт бүртгэл, мэдээллийн үйл ажиллагааны бүтцийг бий болгох, мэргэжилтнүүдийн ур чадварыг дээшлүүлэх;

7.15.14. бүртгэлийн тогтолцооны нэгдсэн сүлжээ, интернэтийн үйлчилгээний зардал, төсвийг нэгтгэн шийдвэрлэх.

7.16. Стратегийн дөрөвдүгээр зорилтын хүрээнд иргэний бүртгэл, эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэл, хуулийн этгээдийн улсын бүртгэлийг төгөлдөршүүлснээр эдийн засгийн эргэлтийг нэмэгдүүлэх, хөрөнгийн арилжаа солилцоог баталгаажуулна.

7.17. Хүрэх үр дүн: Хөрөнгийн арилжаа, солилцоо нээлттэй болж, өмчийн хамгаалалт үнэлгээ сайжирч, хөрөнгийн хэлцэл, арилжаа баталгаажин хөрөнгийн төлөөллийн хэрэглээний суурь тогтолцоо бүрдэнэ.

7.18. Үйл ажиллагааны хүрээ:

7.18.1. бүртгэлийн нэгдсэн тогтолцооны хэрэглээг олон нийтэд сурталчлах;

7.18.2. эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийг боловсронгуй болгох (газар, үл хөдлөх хөрөнгө, барилга орон сууцны бүртгэлийг гэрчилгээжүүлэх), биет бус байдлаар эдийн засгийн эргэлтэд оруулах тогтолцоог бий болгох;

7.18.3. татварын системийг боловсронгуй болгох;

7.18.4. төрийн болон орон нутгийн өмчийг хөрөнгийн эрхийн бүртгэлд хамруулах арга хэмжээ авах;

7.18.5. сургалт, зөвлөгөө зохион байгуулах замаар зээл, үл хөдлөх эд хөрөнгийн барьцааны тогтолцоог боловсронгуй болгох;

7.18.6. даатгалын зах зээлийг өргөжүүлэн, үйлчилгээг боловсронгуй болгох.

7.19. Стратегийн тавдугаар зорилтын хүрээнд бүртгэлийн нэгдсэн тогтолцоонд хамрагдах суурь, төрөлжсөн, төрийн байгууллагын бүртгэл, мэдээллийн сан, системийг шинэчлэн боловсронгуй болгоно.

7.20. Хүрэх үр дүн: Суурь, төрөлжсөн, төрийн байгууллагуудын бүртгэл, мэдээллийн сан, системийн нэгдмэл байдлыг хангана.

7.21. Үйл ажиллагааны хүрээ:

7.21.1. иргэний бүртгэлийг төгөлдөршүүлэх, боловсронгуй болгох чиглэлээр:

а/ харъяатын бүртгэл, улсын хилээр нэвтэрсэн зорчигч, тээврийн хэрэгслийн бүртгэлийг шинэчлэх;

б/ хүн амын өрхийн болон хаягийн бүртгэл, сонгуулийн насны иргэдийн бүртгэлийг шинэчлэх;

в/ иргэдийн овог, нэрийн бичлэгийн стандартыг боловсронгуй болгох.

7.21.2. эд хөрөнгийн эрхийн бүртгэлийг боловсронгуй болгох чиглэлээр:

а/ эд хөрөнгийн эрхийн бүртгэлийг шинэчлэх, хамрах хүрээг өргөтгөн боловсронгуй болгох;

б/ хөрөнгийн арилжаа, солилцоог баталгаажуулах үйл ажиллагааг боловсронгуй болгох;

в/ бусад суурь бүртгэл, мэдээллийн сантай харилцан холбогдох, хөрвөх нөхцөлийг бүрдүүлэх.

7.21.3. хуулийн этгээдийн улсын бүртгэл, мэдээллийн санг боловсронгуй болгох чиглэлээр:

а/ хуулийн этгээдийн бүртгэл, мэдээллийн сан, программм хангамж, нэгдсэн сүлжээ, тогтолцоог боловсронгуй болгох, шинэчлэх;

б/ татварын бүртгэлийн системийг боловсронгуй болгох, бүртгэлийн мэдээллийг шинэчлэх;

в/ төрийн болон төрийн бус байгууллага, шашны байгууллага, улс төрийн нам, хэвлэл мэдээллийн хэрэгсэл, эрүүл мэнд, соёл боловсролын байгууллагын бүртгэлийн тогтолцоог боловсронгуй болгох;

г/ цахим гаалийн тогтолцоог нэвтрүүлж эхлэх;

д/ жижиг, дунд үйлдвэр эрхлэгч иргэн, хуулийн этгээдийн бүртгэлийг бий болгох.

7.21.4. төрөлжсөн болон төрийн байгууллагуудын бүртгэл, мэдээллийн санг боловсронгуй болгох чиглэлээр:

а/ газрын кадастрын бүртгэлийн мэдээллийн сан, орон зайн мэдээллийн дэд бүтцийг боловсронгуй болгох;

б/ төрийн болон орон нутгийн өмчийн тооллого, бүртгэл, цахим сан бүрдүүлэх;

в/ гаалийн бүртгэлийн системийг боловсронгуй болгох, бүртгэлийн мэдээллийг шинэчлэх;

г/ нийгмийн хамгааллын чиглэлийн бүртгэлийн системийг боловсронгуй болгох, бүртгэлийн мэдээллийг шинэчлэх;

д/ аюулгүй байдал, шүүх, цагдаа, гэмт хэргийн бүртгэл, мэдээллийн системийг боловсронгуй болгох, бүртгэлийн мэдээллийг шинэчлэх;

е/ архив, төрийн албан хэрэг хөтлөлтийн бүртгэлийг шинэчлэн хийх;

ж/ банк, санхүү мөнгөний бүртгэлийн системийг боловсронгуй болгох, бүртгэлийн мэдээллийг шинэчлэх;

з/ даатгалын бүртгэлийн системийг боловсронгуй болгох, бүртгэлийн мэдээллийг шинэчлэх;

к/ эрүүл мэндийн чиглэлийн бүртгэлийн системийг боловсронгуй болгох, бүртгэлийн мэдээллийг шинэчлэх;

л/ улс орны батлан хамгаалах мэдээллийн санг боловсронгуй болгох;

м/ бизнес регистрийн мэдээллийн санг боловсронгуй болгох, аж ахуйн нэгж байгууллагын үйл ажиллагааны чиглэл, бүтээгдэхүүн, үйлдвэрлэл, үйлчилгээний нэр төрлийн мэдээллийг шинэчлэх;

н/ бусад.

7.21.5. орон зайн мэдээллийн санг боловсронгуй болгох чиглэлээр:

а/ үндэсний орон зайн мэдээллийн дэд бүтэц байгуулах бодлогын баримт бичиг батлан хэрэгжүүлэх;

б/ үндэсний орон зайн мэдээллийн сан бүрдүүлэх;

в/ "Цахим газар" хөтөлбөрийг боловсруулж батлуулан хэрэгжүүлэх;

г/ газрын кадастрын бүртгэлийн системийг боловсронгуй болгох;

д/ олон зориулттай кадастрын системийг шинээр бий болгох;

е/ гурван хэмжээст кадастрын зураглал болон бүртгэлийн тогтолцоог нэвтрүүлэх.

7.22. Стратегийн зургаадугаар зорилтын хүрээнд хөтөлбөрийг хандивлагч орон, олон улсын байгууллага, төрийн байгууллага, хувийн хэвшил, иргэдэд сурталчлах, хүний нөөцийг хөгжүүлэх, чадавхийг нэмэгдүүлнэ.

7.23. Хүрэх үр дүн: Хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд иргэд, байгууллагуудын оролцоог бүрдүүлж, бүх нийтийн интернэт, мэдээллийн технологийн боловсролыг дээшлүүлнэ.

7.24. Үйл ажиллагааны хүрээ:

7.24.1. бүх нийтийг хөтөлбөрт хамруулах, оролцоог хангах талаар төсөл хэрэгжүүлэх;

7.24.2. бүртгэлийн нэгдсэн тогтолцоог боловсронгуй болгох талаар гадаад, дотоодын зөвлөх үйлчилгээ авах;

7.24.3. үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө, холбогдох зөвлөмж боловсруулан сурталчлах;

7.24.4. тухайн салбарт бүртгэл, мэдээллийн чиглэлээр хэрэгжүүлж байгаа арга хэмжээний талаарх мэдээллийг нэгтгэх, хөрөнгө оруулалтын давхардлыг арилгах, төслүүдийн уялдаа холбоог сайжруулах;

7.24.5. олон нийтийн сургалт, сурталчилгаа зохион байгуулах;

7.24.6. хөтөлбөрийн хэрэгжилтийн явц, үр дүнгийн талаар цуврал уулзалт, семинарыг холбогдох яам, байгууллага, иргэдийн дунд зохион байгуулах, сурталчлах;

7.24.7. мэдээллийн технологийг ашиглах, бүртгэл мэдээллийг нэгдсэн аргачлал, арга зүйгээр явуулах үндэсний боловсон хүчний чадавхийг бүрдүүлэх сургалт, семинарыг зохион байгуулах;

7.24.8. бүртгэл, мэдээллийн сан, техник, технологийн мэргэжилтэй боловсон хүчнийг бэлтгэх, давтан сургах.

**Найм. Хөтөлбөрийн удирдлага, зохион байгуулалт, санхүүжилт, хөтөлбөрийг хэрэгжүүлэх хугацаа**

8.1. Хөтөлбөрийн удирдлага, зохион байгуулалт

8.1.1. хөтөлбөрийн хэрэгжилтийг удирдан зохион байгуулах, түншлэлийг өргөжүүлэх, оролцогч байгууллагуудын үйл ажиллагаар уялдуулан зохицуулах, хяналт тавих, хэрэгжилтийн явцыг Засгийн газарт тайлагнах асуудлыг Монгол Улсад бүртгэл, мэдээллийн нэгдсэн тогтолцоог бий болгох үндэсний хөтөлбөр боловсруулж хэрэгжилтийг удирдан зохион байгуулах Үндэсний хороо хариуцна;

8.1.2. аймаг, нийслэл, сум дүүргийн хэмжээнд хөтөлбөрийн хэрэгжилтийг Засаг даргын Тамгын газар хариуцна;

8.1.3. үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд олон улсын байгууллага, хандивлагч орон, байгууллагууд болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж, иргэдийн дэмжлэгийг авч ажиллана.

8.2. Хөтөлбөрийн санхүүжилтийг дараахь эх үүсвэрээс бүрдүүлнэ:

8.2.1. төсвийн хөрөнгө;

8.2.2. хандивлагч орон, олон улсын байгууллагын тусламж, хандив;

8.2.3. төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж, иргэдийн санаачилгаар хуримтлагдсан тусламж, хандивын хөрөнгө;

8.2.4. гадаад, дотоодын хөрөнгө оруулалт;

8.2.5. бусад эх үүсвэр.

8.3. Бүртгэлийн нэгдсэн тогтолцоог бүрдүүлэх арга хэмжээг санхүүжүүлэх, хэрэгжүүлэхэд Засгийн газар, төсөв, хувийн хэвшил, олон улсын байгууллага, хандивлагч орон, төрийн бус байгууллагын оролцоотойгоор зохион байгуулна.

8.4. Бүртгэлийн нэгдсэн тогтолцоог бүрдүүлэхдээ тодорхой үйлчилгээ, хэрэглээг арилжааны хэлбэрээр явуулах эрхийг хувийн хэвшилд олгох замаар хөтөлбөрийг хэрэгжүүлэх хөрөнгийн эх үүсвэрийн зохих хэсгийг бүрдүүлнэ.

8.5. Техник, технологи, сүлжээ дэд бүтцийн санхүүжилтийг шийдвэрлэхдээ төр, хувийн хэвшлийн түншлэлийн зарчмыг баримтална.

8.6. Монгол Улсад бүртгэлийн нэгдсэн тогтолцоог бий болгох Үндэсний хөтөлбөрийг 2008-2012 онд хэрэгжүүлнэ.

**Ес. Хөтөлбөрийн хэрэгжилтийн хяналт-шинжилгээ, үнэлгээ**

9.1. Хөтөлбөрийн хэрэгжилтийн явц, үр дүнд хяналт тавих, дүн шинжилгээ хийх, үнэлгээ өгөх ажлыг Үндэсний хороо, мэдээлэл, харилцаа холбоо болон бүртгэл, мэдээллийн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага, аймаг, нийслэлийн Засаг даргын Тамгын газар гүйцэтгэнэ.

Засгийн газрын 2008 оны 78 дугаар тогтоолын 2 дугаар хавсралт

## БҮРТГЭЛИЙН НЭГДСЭН ТОГТОЛЦООГ БИЙ БОЛГОХ ҮНДЭСНИЙ ХӨТӨЛБӨРИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ

| Стратегийн зорилтууд | Үйл ажиллагааны хүрээ | Хүрэх үр дүн | Хугацаа /он/ | Хариуцах байгууллага | Хөренгө сая.төг | Эх үүсвэр |
|---|---|---|---|---|---|---|
| 1. Бүртгэлийн нэгдсэн тогтолцооны эрх зүйн орчныг бүрдүүлэх зорилгоор Монгол Улсад хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа хууль, эрх зүйн баримт бичиг, тогтоол шийдвэр, дүрэм, журмыг шинэчлэх, бүртгэлийн нэгдсэн тогтолцооны хууль, эрх зүйн орчинг бүрдүүлнэ | 1.1. Бүртгэлийн ерөнхий болон бусад тулгуур хуулийн төслийг шинээр боловсруулж, батлуулах | Хууль эрх зүй, зохицуулалтын таатай орчин бүрдэнэ | 2008 I-II улирал | ХЗДХЯ Үндэсний хороо МХХТГ БХБЯ Холбогдох бусад яам | | |
| | 1.2 Бүртгэлийн нэгдсэн тогтолцоонд шилжихэд шаардлагатай хууль тогтоомжийг шинэчлэн боловсруулж, батлуулах | | 2008 II улирал | ХЗДХЯ Үндэсний хороо МХХТГ Холбогдох бусад яам | | |
| | 1.3. Зарим хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах, хууль тогтоомжид нийцүүлэн холбогдох дүрэм, журам боловсруулж, батлуулах | | 2008-2009 | ХЗДХЯ МХХТГ Холбогдох бусад яам | | |
| | 1.4. Бүртгэл мэдээллийн ангилал, бүтцийг тодорхойлон түүнд хандах эрхийн түвшинг хууль, дүрэм, журамд нийцүүлэн тогтоох | | 2008 | ХЗДХЯ МХХТГ ГХГЗЗГ ЗГХЭГ | | |
| | 1.5. Бүртгэл, мэдээллийн технологийн ажилтны ажлын байрны тодорхойлолт, эрх үүрэг, цалин хөлсний тогтолцоог боловсронгуй болгох | | 2009 | ХЗДХЯ МХХТГ НХХЯ ЗГХЭГ | | |
| | 1.6. Бүртгэл, мэдээллийн сангуудын ангилал, нэр төрлийг хянан үзэж, төрийн үйл ажиллагаанд зайлшгүй шаардлагатай бусад мэдээллийн санг бий болгох | | 2008- 2009 | ХЗДХЯ ИБМУТ ҮТЕГ ЭХЭҮБГ МХХТГ | | |
| | 1.7. Тэргүүн ээлжинд ашиглах стандартын жагсаалт гаргах, боловсруулан батлуулах арга хэмжээг авах | | 2008- 2009 | ГХГЗЗГ ХЗДХЯ ИБМУТ ҮТЕГ ЭХЭҮБГ СХЗТ | | |
| 2. Бүртгэлийн нэгдсэн тогтолцоонд баримтлах стандарт, техник, технологийн бүтэц, нийтлэг ангилал, нэгдсэн код, дүрэм журам, хаягжилтын системийг бүрдүүлнэ | 2.1. Бүртгэлийн нэгдсэн тогтолцооны архитектурыг боловсруулан батлах | Бүртгэлийн нэгдсэн тогтолцооны суурь, дүрэм, журам, стандарт, хаягжилтын систем, тогтолцоо бүрдэнэ | 2008 | Үндэсний хороо МХХТГ | | |
| | 2.2. Хаягжуулалтын нэгдсэн шинэ систем бий болгох, хэрэгжилтийг зохион байгуулах | | 2008-2009 | ХЗДХЯ БХБЯ Нийслэл аймаг дүүрэг сумын ЗДТГ ГХГЗЗГ | | |
| | 2.3. Мэдээллийн аюулгүй байдлын олон улсын стандартыг боловсруулан батлуулж, мөрдүүлэх, удирдлага арга зүйгээр хангах | | 2008-2009 | СХЗТ МХХТГ ГХГЗЗГ | | |
| | 2.4. Бүртгэл мэдээллийн нэгдсэн тогтолцоонд хамрагдах мэдээллийн үзүүлэлтүүдийн тодорхойлолт, цуглуулах арга зүй аргачлал, хэрэглэгдэх нэгдсэн код, стандарт, ангиллын тогтолцоог статистикийн төв байгууллагаар баталгаажуулан хэрэгжүүлэх | | 2008-2009 | СХЗТ МХХТГ ТЕГ УМХГ ҮСХ | | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | 2.5. Нэгдсэн сүлжээнд ашиглагдах сүлжээний болон хэрэглэгчийн тоног, төхөөрөмжийн нөхцөл, шаардлагыг тогтоох, баталгаажуулалтын тогтолцоог бий болгох | | 2008 – 2012 | МХХТГ СХЗТ ХХЗХ ГХГЗЗГ | 200.0 | Улсын төсөв |
| | 2.6. Бүртгэлийн нэгдсэн тогтолцооны техник, технологийн суурь, нэгдсэн стандартыг боловсруулж хэрэгжүүлэх, хэрэгжилтэд хяналт тавихтай холбоотой дүрэм, журмыг батлуулах | | 2008 | ХЗДХЯ СХЗТ ИБМУТ ЭХЗУБГ МХХТГ ГХГЗЗГ | | |
| | 2.7. Латин үсгийн галигчлалын нэгдмэл стандарт, кирилл үсгийн юникодыг боловсронгуй болгох | | 2008 | МХХТГ СХЗТ | 10.0 | Улсын төсөв |
| | 2.8. Зип кодыг нэвтрүүлэх ажлыг дэмжих, хэрэглээний талаар сургалт, сурталчилгаа зохион байгуулах | | 2008-2009 | ЗТАЖЯ МХХТГ ХХЗХ Нийслэл аймаг дүүрэг сумын ЗДТГ | 100.0 | Улсын төсөв |
| | 2.9. Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгжийн кодыг боловсронгуй болгон хэрэгжүүлэх | | 2008 | УСХ СХЗТ | 50.0 | Улсын төсөв |
| | 2.10. Орон зайн мэдээллийн сангийн холбогдох стандартыг батлуулах, хэрэглээнд нэвтрүүлэх | | 2008 | БХБЯ УСХ СХЗТ ГХГЗЗГ | | |
| 3. Суурь, төрөлжсөн, төр.захиргааны байгууллагуудын мэдээллийн сан бүрдүүлэх, бүртгэлийн тогтолцооны мэдээллийн сүлжээ, дэд бүтцийг байгуулах, иргэний ухаалаг үнэмлэх олгоно | 3.1. Үндэсний өгөгдөл мэдээллийн төвийг байгуулах, холбогдох байгууллагуудын бүртгэлийн мэдээллийг байршуулах, статистикийн төв байгууллагатай бүртгэл мэдээллийг солилцох төлөвлөгөөг боловсруулж, хэрэгжүүлэх | | 2008 | МХХТГ ТЕГ УСХ | | |
| | 3.2. Монгол Улсын иргэний эрхийг баталгаажуулах, төрийн үйлчилгээ, хэрэглээг хүртэх иргэний ухаалаг үнэмлэхийг бий болгох, Монгол Улсын иргэдэд олгох арга хэмжээг үе шаттай хэрэгжүүлэх | | 2008 | ХЗДХЯ ИБМУТ | | |
| | 3.3. Орон зайн мэдээллийн нэгдсэн санг бүрдүүлэх, суурь болон бусад мэдээллийн сантай уялдуулах | | 2008-2009 | ЭХЗУБГ МХХТГ УТЕГ ХЗДХЯ ГХГЗЗГ | 3000.0 | Улсын төсөв |
| | 3.4. Иргэний бүртгэл, паспортын хяналтын нэгдсэн сүлжээг иж бүрэн болгон хэрэгжүүлэх | | 2008 | ИБМУТ МХХТГ | | |
| | 3.5. Иргэний бүртгэл, мэдээллийн улсын нэгдсэн сүлжээ төслийг хэрэгжүүлж эхний ээлжинд аймаг, нийслэл, дүүргийн бүртгэлийн үйл ажиллагааг онлайн сүлжээнд холбох | | 2008 | ИБМУТ | | |
| | 3.6. Үндэсний өгөгдөл мэдээллийн төвийн нөөцийн системийг Улаанбаатар хотоос алсад байгуулах, дэд бүтцийн асуудлыг шийдвэрлэх, мэдээлэл, нөөц сан бий болгох ажлыг зохион байгуулах | | 2008 | ХЗДХЯ МХХТГ ГХГЗЗГ ЗГХЭГ | | |
| | 3.7. Үндэсний өгөгдөл мэдээллийн төв, төрийн захиргааны төв байгууллагууд, агентлагууд, холбогдох аж ахуйн нэгж байгууллагуудыг холбосон өндөр хурдны шилэн кабелийн интранет сүлжээг байгуулж, ашиглалтад оруулах | | 2012 | ЗГХЭГ МХХТГ ТЕГ | | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | 3.8. Бүртгэлийн тогтолцоог бүрдүүлэх программ хангамжийг лицензжүүлж, боловсронгуй болгох, мэдээллийн системийн харилцан уялдаа, мэдээллийн аюулгүй байдлыг хангах | | 2009-2010 | МХХТГ ИБМУТ ЭХЭУБГ ГХГЗЗГ | 300.0 | Улсын төсөв, хувийн хөрөнгө оруулалт |
| | 3.9 Архив, цаасан хэлбэрийн мэдээллийн санг цахим хэлбэрт хөрвүүлэх, бүртгэлийн нэгдсэн санд нэгтгэх | | 2008-2009 | МХХТГ ГХЯ ТЕГ | 200.0 | Улсын төсөв |
| | 3.10. Нийслэлийн төр захиргааны байгууллагууд, дүүрэг, хороо, цэцэрлэг, сургууль, эмнэлгүүдийг өндөр хурдны сүлжээгээр холбох, нийслэлийн бүртгэл, мэдээллийн солилцооны дэд бүтцийг боловсронгуй болгох | | 2008-2010 | МХХТГ НЗДТГ | | |
| | 3.11. Аймаг, дүүрэг, сум, хороонд үндэсний бүртгэлийн нэгдсэн интранет сүлжээг ашиглах боломжийг бүрдүүлэх | | 2008-2012 | МХХТГ ИБМУТ ЭХЭУБГ бүх шатны ЗДТГ | | |
| | 3.12. Үндэсний орон зайн мэдээллийн дэд бүтэц байгуулах, мэдээллийн сан бүрдүүлэх, программ хангамжийг боловсронгуй болгох талаар хэрэгжүүлж байгаа болон хэрэгжүүлэх төсөл, хөтөлбөрүүдийн уялдаа холбоог сайжруулах | | 2008-2009 | ЗГХЭГ МХХТГ БХБЯ ГХГЗЗГ | | |
| | 3.13. Бүртгэл, мэдээллийн удирдлагын тогтолцоог шинэчлэх, хөдөө орон нутагт бүртгэл мэдээллийн үйл ажиллагааны бүтцийг бий болгох, мэргэжилтнүүдийн ур чадварыг дээшлүүлэх | | 2008-2009 | ХЗДХЯ МХХТГ УСХ | | |
| | 3.14. Бүртгэлийн тогтолцооны нэгдсэн сүлжээ, интернэтийн үйлчилгээний зардал, төсвийг нэгтгэн шийдвэрлэх | | 2008-2009 | МХХТГ ХХЗХ | | |
| 4. Иргэний бүртгэл, эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэл, хуулийн этгээдийн улсын бүртгэлийг төгөлдөршүүлснээр эдийн засгийн эргэлтийг нэмэгдүүлэх, хөрөнгийн арилжаа солилцоог баталгаажуулна | 4.1. Бүртгэлийн нэгдсэн тогтолцооны хэрэглээг олон нийтэд сурталчлах | Хөрөнгийн арилжаа, солилцоо нээлттэй болж, өмчийн хамгаалалт үнэлгээ сайжран, хөрөнгийн хэлцэл, арилжаа алгаажин хөрөнгийн төлөөллийн бүртгэлийн хэрэглээний суурь тогтолцоо бүрдэнэ. | 2008-2012 | МХХТГ Үндэсний хороо ЭХЭУБГ | 100.0 | Улсын төсөв, хувийн хөрөнгө оруулалт |
| | 4.2. Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийг боловсронгуй болгох (газар, үл хөдлөх хөрөнгө, барилга орон сууцны бүртгэлийг гэрчилгээжүүлэх), биет бус байдлаар эдийн засгийн эргэлтэд оруулах тогтолцоог бий болгох | | 2008-2012 | ЭХЭУБГ Үндэсний хороо | | |
| | 4.3. Татварын системийг боловсронгуй болгох | | 2008-2010 | ҮТЕГ Үндэсний хороо | | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | 4.4. Төрийн болон орон нутгийн өмчийг хөрөнгийн эрхийн бүртгэлд хамруулах арга хэмжээг авах | | 2008-2010 | ТӨХ ЭХЭУБГ бүх шатны ЗДТГ | | |
| | 4.5. Сургалт, зөвлөгөө зохион байгуулах замаар зээл болон үл хөдлөх хөрөнгийн барьцааны тогтолцоог боловсронгуй болгох | | 2008-2012 | Үндэсний хороо СЗХ | 50.0 | Улсын төсөв |
| | 4.6 Даатгалын зах зээлийг өргөжүүлэн үйлчилгээг боловсронгуй болгох | | 2008-2012 | СЯ СЗХ | 50.0 | Хувийн хөрөнгө оруулалт |
| 5. Бүртгэлийн нэгдсэн тогтолцоонд хамрагдах суурь, төрөлжсөн, төрийн байгууллагуудын бүртгэл, мэдээллийн сан, системийг шинэчлэн боловсронгуй болгоно. | 5.1. Иргэний бүртгэлийг төгөлдөршүүлэх, боловсронгуй болгох чиглэлээр: | Суурь, төрөлжсөн, төр захиргааны байгууллагуудын бүртгэл, мэдээллийн сан, системийн нэгдмэл байдлыг хангана | | | | |
| | 5.1.1. Гадаадын иргэн, харъяатын бүртгэл, улсын хилээр нэвтэрсэн зорчигч, тээврийн хэрэгслийн бүртгэлийг шинэчлэх | | 2008-2012 | ХЗДХЯ, ИБМУТ бүх шатны ЗДТГ | | |
| | 5.1.2. Хүн амын өрхийн болон хаягийн бүртгэл, сонгуулийн насны иргэдийн бүртгэлийг шинэчлэх | | 2008 | ХЗДХЯ ИБМУТ | 300.0 | Улсын төсөв |
| | 5.1.3. Иргэдийн овог, нэрийн бичлэгийн стандартыг боловсронгуй болгох | | 2008 | СХЗТ МХХТГ | 10.0 | Улсын төсөв |
| | 5.2. Эд хөрөнгийн эрхийн бүртгэлийг шинэчлэх, хамрах хүрээг өргөтгөн боловсронгуй болгох чиглэлээр: | | | | | |
| | 5.2.1. Эд хөрөнгийн бүртгэлийг шинэчлэх боловсронгуй болгох | | 2008-2010 | ЭХЭУБГ | | |
| | 5.2.2. Хөрөнгийн арилжаа, солилцоог баталгаажуулах үйл ажиллагааг боловсронгуй болгох | | 2008-2010 | ЭХЭУБГ | | |
| | 5.2.3. Бусад суурь бүртгэл мэдээллийн сантай харилцан холбогдох хөрвөх нөхцөлийг бүрдүүлэх | | 2008-2010 | ЭХЭУБГ | | |
| | 5.3. Хуулийн этгээдийн эрхийн улсын бүртгэл, мэдээллийн санг боловсронгуй болгох чиглэлээр: | | | | | |
| | 5.3.1. Хуулийн этгээдийн бүртгэл, мэдээллийн сан, програм хангамж, нэгдсэн сүлжээ, тогтолцоог боловсронгуй болгох, шинэчлэх | | 2008-2009 | ХЗДХЯ | 120.0 | Улсын төсөв |
| | 5.3.2. Татварын бүртгэлийн системийг боловсронгуй болгох, бүртгэлийн мэдээллийг шинэчлэх | | 2008-2009 | ҮТЕГ | 580.0 | Улсын төсөв, гадаадын зээл, тусламж |
| | 5.3.3. Төсөвт, төрийн болон төрийн бус байгууллага, холбоо, шашны байгууллага, улс төрийн нам, хэвлэл мэдээллийн хэрэгсэл, эрүүл мэнд, соёл боловсролын байгууллагуудын бүртгэлийн тогтолцоог боловсронгуй болгох | | 2008-2010 | Үндэсний хороо бүх шатны ЗДТГ | | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | 5.3.4. Иргэн бүр татвар төлдөг болон цахим гаалийн тогтолцоог нэвтрүүлж эхлэх | | 2008-2010 | ҮТЕГ ГЕГ | 100.0 | Улсын төсөв |
| | 5.3.5. Жижиг, дунд үйлдвэр эрхлэгч иргэн, хуулийн этгээдийн бүртгэлийг боловсронгуй болгох | | 2008-2009 | ҮТЕГ | 50.0 | Улсын төсөв |
| | 5.4. Төрөлжсөн болон төр захиргааны байгууллагуудын бүртгэл, мэдээллийн санг боловсронгуй болгох чиглэлээр: | | | | | |
| | 5.4.1. Газрын кадастрын бүртгэлийн мэдээллийн сан, орон зайн мэдээллийн дэд бүтцийг боловсронгуй болгох | | 2008-2009 | ХЗДХЯ ГХГЗЗГ | | |
| | 5.4.2. Төрийн болон орон нутгийн өмчийн тооллого, бүртгэл, цахим сан бүрдүүлэх | | 2008-2009 | ТӨХ бүх шатны ЗДТГ | | |
| | 5.4.3. Гаалийн бүртгэлийн системийг боловсронгуй болгох, бүртгэлийн мэдээллийг шинэчлэх | | 2008-2009 | УГЕГ | 500.0 | Улсын төсөв, гадаадын зээл, тусламж |
| | 5.4.4. Нийгмийн хамгааллын чиглэлийн бүртгэлийн системийг боловсронгуй болгох, бүртгэлийн мэдээллийг шинэчлэх | | 2008-2009 | НХХЯ | 600.0 | Улсын төсөв |
| | 5.4.5. Аюулгүй байдал, шүүх, цагдаа гэмт хэргийн бүртгэл, мэдээллийн системийг боловсронгуй болгох, бүртгэлийн мэдээллийг шинэчлэх | | 2008-2009 | ХЗДХЯ бүх шатны ЗДТГ | 300.0 | Улсын төсөв |
| | 5.4.6. Архив, төрийн албан хэрэг хөтлөлтийн бүртгэлийг шинэчлэн хийх | | 2008-2009 | ҮАГ | 250.0 | Улсын төсөв |
| | 5.4.7. Банк, санхүү мөнгөний бүртгэлийн системийг боловсронгуй болгох, бүртгэлийн мэдээллийг шинэчлэх | | 2008-2009 | СЯ СЗХ ТЕГ | | |
| | 5.4.8. Даатгалын бүртгэлийн системийг боловсронгуй болгох, бүртгэлийн мэдээллийг шинэчлэх | | 2008-2009 | СЯ СЗХ | 200.0 | Хувийн хөрөнгө оруулалт |
| | 5.4.9. Эрүүл мэндийн чиглэлийн бүртгэлийн системийг боловсронгуй болгох, бүртгэлийн мэдээллийг шинэчлэх /"Эрүүл Монгол хүн" хөтөлбөрийн хүрээнд 4 төрлийн шинэ мэдээллийн санг бүрдүүлэх/ | | 2008-2009 | ЭМЯ | | |
| | 5.4.10. Улс орны батлан хамгаалах мэдээллийн санг боловсронгуй болгох | | 2008-2010 | БХЯ | 100.0 | Улсын төсөв |
| | 5.4.11. Бизнес регистрийн мэдээллийн санг боловсронгуй болгох, аж ахуйн нэгж байгууллагын үйл ажиллагааны чиглэл, бүтээгдэхүүн, үйлдвэрлэл, үйлчилгээний нэр төрлийг шинэчлэн тогтоох | | 2008-2010 | Үндэсний хороо ҮСХ | 100.0 | Улсын төсөв |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | 5.5. Орон зайн мэдээллийн санг боловсронгуй болгох чиглэлээр: | | | | | |
| | 5.5.1. Үндэсний орон зайн мэдээллийн дэд бүтэц байгуулах бодлогын баримт бичиг батлах хэрэгжүүлэх | | 2008 | БХБЯ ГХГЗЗГ МХХТГ | 20.0 | Улсын төсөв |
| | 5.5.2. Үндэсний орон зайн мэдээллийн сан бүрдүүлэх | | 2008-2012 | ГХГЗЗГ | 8650.0 | Улсын төсөв |
| | 5.5.3. "Цахим газар" хөтөлбөрийг боловсруулж батлуулан хэрэгжүүлэх | | 2008 | БХБЯ ГХГЗЗГ МХХТГ | 5400.0 | Улсын төсөв |
| | 5.5.4. Газрын кадастрын бүртгэлийн системийг боловсронгуй болгох | | 2008-2009 | БХБЯ ГХГЗЗГ | 650.0 | Улсын төсөв |
| | 5.5.5. Олон зориулалт кадастрын системийг шинээр бий болгох | | 2008-2010 | БХБЯ ГХГЗЗГ | 300.0 | Улсын төсөв |
| | 5.5.6. Гурван хэмжээст кадастрын зураглал болон бүртгэлийн тогтолцоог нэвтрүүлэх | | 2008-2012 | БХБЯ, ГХГЗЗГ | 2900.0 | Улсын төсөв |
| 6. Хөтөлбөрийг хандивлагч орон, олон улсын байгууллага, төрийн байгууллага, хувийн хэвшил, иргэдэд сурталчлах, хүний нөөцийг хөгжүүлэх, чадавхийг нэмэгдүүлнэ. | 6.1. Бүх нийтийг хөтөлбөрт хамруулах, оролцоог хангах талаар төсөл, хөтөлбөрийг хэрэгжүүлэх | Хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд иргэд, байгууллагуудын оролцоог бүрдүүлж, бүх нийтийн интернэт, мэдээллийн технологийн боловсролыг дээшлүүлнэ | 2008-2012 | Үндэсний хороо | 50.0 | Улсын төсөв |
| | 6.2. Бүртгэлийн нэгдсэн тогтолцоог боловсронгуй болгох талаар гадаад, дотоодын зөвлөх үйлчилгээг авах | | 2008-2012 | Үндэсний хороо МХХТГ | 40.0 | Улсын төсөв, зээл, тусламж |
| | 6.3. Үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө, холбогдох зөвлөмж боловсруулан сурталчлах | | 2008 | Үндэсний хороо МХХТГ | 10.0 | Улсын төсөв |
| | 6.4. Салбар бүрт энэ чиглэлээр хэрэгжүүлж байгаа ажлуудын мэдээллийг нэгтгэх, давхардсан хөрөнгө оруулалтаас зайлсхийх, төслүүдийн уялдаа холбоог сайжруулах | | 2008 | Үндэсний хороо ЗГХЭГ | 10.0 | Улсын төсөв |
| | 6.5. Олон нийтийн сургалт, сурталчилгаа зохион байгуулах | | 2008 | Үндэсний хороо бүх шатны ЗДТГ | 100.0 | Улсын төсөв, хандив |
| | 6.6. Хөтөлбөрийн хэрэгжилтийн явц, үр дүнгийн талаар цуврал уулзалт, семинарыг холбогдох яам, байгууллага, иргэдийн дунд зохион байгуулах, сурталчлах | | 2008 | Үндэсний хороо МХХТГ | 100.0 | Улсын төсөв |
| | 6.7. Мэдээллийн технологийг ашиглах, бүртгэл мэдээллийг нэгдсэн аргачлал, арга зүйгээр явуулах Үндэсний боловсон хүчний чадавхи бүрдүүлэх сургалт, семинарыг зохион байгуулах | | 2008-2010 | МХХТГ УСХ | 500.0 | Улсын төсөв |
| | 6.8. Бүртгэл, мэдээллийн сан, техник, технологийн мэргэжилтэй боловсон хүчнийг бэлтгэх, давтан сургах | | 2008-2010 | МХХТГ УСХ | 500.0 | Улсын төсөв |

Засгийн газрын 2008 оны 78 дугаар
тогтоолын 3 дугаар хавсралт

## МОНГОЛ УЛСАД БҮРТГЭЛИЙН НЭГДСЭН ТОГТОЛЦООГ БИЙ БОЛГОХ ҮНДЭСНИЙ ХӨТӨЛБӨРИЙН ХҮРЭЭНД ХЭРЭГЖҮҮЛЭХ ТЭРГҮҮЛЭХ АЧ ХОЛБОГДОЛ БҮХИЙ ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭ

| Зорилт, арга хэмжээ | Хугацаа | Санхүүжилт | | Хэрэгжүүлэх байгууллага | | Хүрэх үр дүн |
|---|---|---|---|---|---|---|
| | | Хэмжээ сая.төг | Эх үүсвэр | Үндсэн | Хамтрагч | |
| **Нэг. Хууль, эрх зүйн орчин бүрдүүлэх талаар** | | | | | | |
| 1.1. Шинээр боловсруулж, батлуулах шаардлагатай хуулиуд: | | 30.0 | Улсын төсөв | | | Хууль, эрх зүйн таатай орчин бүрдэнэ |
| 1.1.1. бүртгэлийн талаарх ерөнхий хууль | 2008 I улирал | | | ХЗДХЯ | ЕТГ Үндэсний хороо | |
| 1.1.2. хөдлөх эд хөрөнгийн барьцааны эрхийн бүртгэлийн талаархи хууль | 2008 II улирал | | | ХЗДХЯ | БХБЯ Үндэсний хороо, МХХТГ,ГХГЗЗГ | |
| 1.1.3. цахим гарын үсгийн талаархи хууль | 2008 I улирал | | | ХЗДХЯ МХХТГ | Үндэсний хороо, ГХГЗЗГ | |
| 1.1.4. мэдээллийн аюулгүй байдлын талаархи хууль | 2008 I улирал | | | ХЗДХЯ МХХТГ | Үндэсний хороо, ГХГЗЗГ | |
| 1.1.5. газар зүй, орон зайн мэдээллийн талаархи хууль | 2008 II улирал | | | БХБЯ | ХЗДХЯ Үндэсний хороо, МХХТГ,ГХГЗЗГ | |
| 1.2. Шинэчлэн боловсруулж, батлуулах хуулиуд: | | 20.0 | Улсын төсөв | | | Хууль, эрх зүйн таатай орчин бүрдэнэ |
| 1.2.1. Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай | 2008 I улирал | | | ХЗДХЯ | СЯ, Үндэсний хороо, МХХТГ, ГХГЗЗГ | |
| 1.2.2. Эд хөрөнгө өмчлөх эрх, түүнтэй холбоотой эд хөрөнгийн бусад эрхийн улсын бүртгэлийн тухай | 2008 I улирал | | | БХБЯ | ХЗДХЯ, Үндэсний хороо, МХХТГ, ЭХЭУБГ,ГХГЗЗГ | |
| 1.2.3. Харилцаа холбооны тухай хууль | 2008 I улирал | | | ХЗДХЯ, МХХТГ | Үндэсний хороо, МХХТГ, ГХГЗЗГ | |
| 1.2.4. Татварын ерөнхий хууль | 2008 I улирал | | | СЯ | ХЗДХЯ, Үндэсний хороо, МХХТГ,ГХГЗЗГ | |
| 1.2.5. Кадастрын зураглал ба газрын кадастрын тухай хууль | 2008 I улирал | | | БХБЯ | ХЗДХЯ, Үндэсний хороо, МХХТГ,ГХГЗЗГ | |
| 1.2.6. Газрын тухай хууль | 2008 I улирал | | | БХБЯ | ХЗДХЯ, Үндэсний хороо, МХХТГ,ГХГЗЗГ | |
| 1.3. Нэмэлт, өөрчлөлт оруулах хуулиуд: | | | | | | |
| 1.3.1. Жижиг, дунд үйлдвэрийн тухай | 2008 I улирал | | | ҮХЯ | ХЗДХЯ, Үндэсний хороо, МХХТГ,ГХГЗЗГ | |
| 1.3.2. Иргэний хууль /цахим хэлцлийн талаар/ | 2008 I улирал | | | ХЗДХЯ | Үндэсний хороо, МХХТГ, ГХГЗЗГ | |
| 1.3.3. Статистикийн тухай | 2008 I улирал | | | СЯ, ҮСХ | ХЗДХЯ, Үндэсний хороо, ХХТГ, ГХГЗЗГ | |
| 1.3.4. Иргэний бүртгэлийн тухай | 2008 I улирал | | | ХЗДХЯ | Үндэсний хороо, МХХТГ, ГХГЗЗГ, ИБМУТ | |
| **Хоёр. Хаягжилтын нэгдсэн систем бий болгох талаар** | | | | | | |
| 2.1. Монгол Улсад хаягжилтын нэгдсэн системийг газар зүйн байрлалд тулгуурлан бий болгох, хаягийн бүртгэлийг тодорхой болгох, түүнийг хэрэглээнд нэвтрүүлэхтэй холбоотой аргачлал, журам, дүрмийг боловсруулж, батлуулах | 2008 I улирал | 20.0 | Улсын төсөв | ХЗДХЯ, МХХТГ, ГХГЗЗГ | Холбогдох бусад яам | Хаягжилтын нэгдсэн системд шилжих эрх зүйн орчин бүрдэнэ |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| 2.2. Солбицолд суурилсан код (NAC)-ыг хаягжуулалтын нэгдсэн систем болгон нэвтрүүлэхэд шаардлагатай зураг, өгөгдлөөр хангах ажлыг зохион байгуулах | 2008 П улирал | 500.0 | Улсын төсөв, Хувийн хөренгө оруулалт | ХЗДХЯ, МХХТГ, ГХГЗЗГ | Аймаг, нийслэлийн ЗДТГ, бусад холбогдох байгууллага | Хаягжилтын нэгдсэн системд шилжих бэлтгэл ажлыг эхлүүлэх |
| 2.3. Хаягжилтын нэгдсэн системийг бий болгоход эхний ээлжинд хэрэгжүүлэх шаардлагатай зарим арга хэмжээний талаар Засгийн газрын тогтоолын төсөл боловсруулж зохих журмын дагуу шийдвэрлүүлэх | 2008 I улирал | | | ХЗДХЯ, БХБЯ, МХХТГ | ЗГХЭГ | Хаягжилтын нэгдсэн системд шилжих бэлтгэл ажлыг тодорхой болгоно |
| 2.4. Газар зүйн солбицлын мэдээллийг хөрвүүлэн (NAC кодын) өгөгдлийн сан бүрдүүлэх | 2008 Ш улирал | 3500.0 | Улсын төсөв, Хувийн хөренгө оруулалт | ХЗДХЯ, МХХТГ, ГХГЗЗГ | Аймаг, нийслэлийн ЗДТГ, Бусад холбогдох байгууллага | Дахин давтагдашгүй байршлын хаягжилтын системийн суурь нөхцөл бүрдэнэ |
| 2.5. Хаягжилтын нэгдсэн системийг бий болгон хаягийг оноох, байршуулах ажлыг гүйцэтгэх | 2008 IV улирал | 3000.0 | Улсын төсөв, Хувийн хөренгө оруулалт | ХЗДХЯ, МХХТГ, ГХГЗЗГ | Аймаг, нийслэлийн ЗДТГ | Хаягжуулалтын нэгдсэн шинэ систем бий болно |
| 2.6. Хаягжуулалтын нэгдсэн тогтолцоог иж бүрнээр бүрдүүлэн эрх зүй, төрөлжсөн, төрийн байгууллагуудын бүртгэл, байршилд суурилсан мэдээллийн сангийн үйлчилгээ, хэрэглээнд нэвтрүүлэх | 2009 Ш улирал | 1000.0 | Улсын төсөв, Хувийн хөренгө оруулалт | ХЗДХЯ, БХБЯ, Аймаг, нийслэлийн ЗДТГ | Бүх шатны төрийн болон аж ахуйн нэгж байгууллага | Мэдээллийн технологи дээр суурилсан байрлалтай холбоотой олон төрлийн үйлчилгээ бий болно |
| 2.7. Үндэсний өгөгдөл мэдээллийн нөөц төвийг барьж байгуулах | 2010-2012 | 6000.0 | Улсын төсөв, зээл, тусламж | МХХТГ | ЗГХЭГ БХБЯ | Мэдээллийн сангуудын нөөц хувь бий болгож, онцгой байдлын үед мэдээлэл алдагдах, устгагдахаас хамгаалагдана |
| Гурав. Эд хөрөнгийн эрхийн бүртгэлийн тогтолцоог төгөлдөршүүлэх талаар | | | | | | |
| 3.1. Төрийн болон орон нутгийн өмчийн бүртгэлийг сайжруулах талаар авах арга хэмжээний талаар Засгийн газрын зохих шийдвэр гаргуулах | 2008 Ш улирал | | | Төрийн өмчийн хороо | Аймаг, нийслэлийн ЗДТГ, Сангийн яам | |
| 3.2. Төрийн болон орон нутгийн өмч, санхүүгийн лизинг, ашигт малтмалын лиценз, үнэт цаасны эрхийг эрхийн улсын бүртгэлд хамруулах тооцоо, судалгаа хийх | 2008 Ш улирал | 20.0 | Улсын төсөв | БХБЯ ЭХЭУБГ | ТӨХ, АМГТХЭГ, СЗХ | Эд хөрөнгийн эрхийн бүртгэлд хамруулах бэлтгэл ажил хангагдана |
| 3.3. Төрийн болон орон нутгийн өмчийн тооллого, үнэлгээ явуулах | 2008 П улирал | 200.0 | Улсын төсөв | ТӨХ, Аймаг, нийслэ-лийн ЗДТГ | Холбогдох яам, агентлаг, Төсвийн ерөнхийлөн захирагчид | Төрийн болон орон нутгийн өмчийн бодит дүнг нэгтгэн гаргах, түүх соёлын дурсгалт зүйлсийг үнэлэх |
| 3.4. Төрийн болон өмчийн бүртгэлийн программ хангамжийг бүртгэлийн нэгдсэн тогтолцоотой уялдуулан стандартын дагуу хөтлөн явуулах | 2008 IV улирал | 100.0 | Улсын төсөв | ТӨХ, Аймаг, нийслэ-лийн ЗДТГ | Бүх шатны төрийн байгууллага, Төрийн болон орон нутгийн өмчит аж ахуйн нэгж байгууллага | Төрийн болон орон нутгийн өмчийн дүн мэдээг байнга үнэн зөв хөтлөн явуулж байх боломж бүрдэнэ |
| 3.5. Төрийн болон орон нутгийн өмч, санхүүгийн лизингийн эрх, ашигт малтмалын хайгуулын болон ашиглалтын эрх болон үнэт цаасны бүртгэлийг Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлд хамруулах | 2008 IV улирал | 3358.0 | Улсын төсөв | ЭХЭУБГ, ТӨХ | АМГТХЭГ, СЗХ | Төрийн болон орон нутгийн өмч нь эд хөрөнгийн бүртгэлийн нэгдсэн тогтолцоонд шилжих нөхцөл бүрдэнэ |

| Зургаа. Мэдээлэл, холбооны техник, технологи, сүлжээ, дэд бүтцийг өргөтгөн шинэчлэх талаар | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| 6.1. Бүртгэлийн нэгдсэн тогтолцоонд шилжихэд шаардлагатай дэд бүтцийн архитектур, техник, технологи, стандарт, нэгдсэн код, программ хангамж, удирдлагын систем, бүтцийг бүрдүүлэх | 2008 II улирал | 250.0 | Улсын төсөв | МХХТГ | ЗГХЭГ, СХЗТ | Мэдээлэл солилцох нэгдмэл орчинг бүрдүүлнэ |
| 6.2 Улаанбаатар хотын хэмжээнд төрийн байгууллагуудыг холбох өндөр хурдын суурь сүлжээг (backbone) байгуулах | 2008 II улир-лаас | 5000.0 | Хувийн хөрөнгө оруулалт | МХХТГ | ЗГХЭГ | Өндөр хурдны нэгдсэн сүлжээгээр бүртгэлийн мэдээлэл дамжуулах, харилцан холбогдох боломж бүрдэнэ |
| 6.3. Үндэсний өгөгдөл мэдээллийн нэгдсэн төвийг барьж байгуулах | 2008 IV улирал | 6000.0 | БНСУ-ын Засгийн газрын буцалтгүй тусламж | МХХТГ | ЗГХЭГ БХБЯ | Суурь болон төрөлжсөн мэдээллийн санг нэгтгэж, мэдээллийн нууцлалт аюулгүй байдлыг хангана |
| 6.4. Үндэсний өгөгдөл мэдээллийн нэгдсэн төв, Төрийн захиргааны төв байгууллагууд, агентлагуудыг суурь сүлжээнд холбох | 2008 он II улирлаас 2009 он | 2000.0 | Улсын болон орон нутгийн төсөв | МХХТГ | ЗГХЭГ | Төрөлжсөн мэдээллийн сан, интранет сүлжээг байгуулах, интернетийн өндөр хурдын гарцанд холбогдоно |
| 6.5. Иргэний бүртгэл, мэдээллийн улсын нэгдсэн сүлжээ төслийг хэрэгжүүлж эхний ээлжинд аймаг, нийслэл, дүүргийн бүртгэлийн үйл ажиллагаар онлайн сүлжээнд холбох | 2008-2009 | 565,0 | Улсын төсөв | ИБМУТ | ХЗДХЯ Аймаг, нийслэлийн ЗДТГ | Иргэдийн шилжилт хөдөлгөөн, урсгал сайжирч, хүн ам бүртгэлийн төвлөрсөн мэдээллийн сан үүснэ |
| 6.6. Томоохон хот суурин газрууд, аймаг, сумдад суурь, түгээх сүлжээг орон нутгийн нөхцөл байдалд зохицуулан байгуулах | 2008 | 8100.0 | Улсын төсөв | МХХТГ | ЗГХЭГ Аймаг, сумдын ЗДТГ | Аймаг, сум, дүүрэг, хороог хамарсан нэгдсэн бүртгэлийн интранет сүлжээг ашиглах боломж бүрдэнэ |
| 6.7. Хөдөө орон нутагт бүртгэлийн нэгдсэн тогтолцооны дэд бүтцийг цаашид өргөтгөх, хэрэглээг бий болгох | 2010 | 4000.0 | Улсын болон орон нутгийн төсөв, гадаадын зээл тусламж | МХХТГ | ЗГХЭГ Аймаг, сумдын ЗДТГ | Хөдөө орон нутгийн иргэд бүртгэлийн нэгдсэн үйл ажиллагаанд хамрагдана |

Монгол Улсын Их Хурлын Тамгын газраас гаргав.
**Хаяг: <<Төрийн мэдээлэл>> эмхтгэлийн зөвлөл.**
Улаанбаатар- 12
Төрийн ордон
☎ 265958
Индекс 14003
Улсын Их Хурлын Тамгын газрын
Хэвлэх хэсэгт хэвлэв.
☎ 329487
Хэвлэлийн хуудас 4